



United Nations
Educational, Scientific and
Cultural Organization



Diversity of
Cultural Expressions

ᠬᠤᠷᠠᠨᠭᠤᠢ
ᠰᠣᠶ᠋ᠢ
ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠭ
ᠳᠠᠬᠢᠨ
ᠲᠣᠳᠣᠷᠬᠣᠢᠯᠣᠬᠤ ᠨᠢ

ХУРААНГУЙ

СОЁЛЫН БОДЛОГЫГ ДАХИН ТОДОРХОЙЛОХ НЬ

Хөгжлийн төлөөх соёлын
илэрхийллийн олон төрөл
зүйлийг дэмжих арван жил

2015

2005 оны Конвенцийн
дэлхийн тайлан

ӨМНӨХ ҮГ

Олон улсын түвшинд анх удаа саяхан батлагдсан 2030 он хүртэлх Нэгдсэн Үндэстний Байгууллагын Тогтвортой хөгжлийн хөтөлбөр нь тогтвортой хөгжилд тулгарч буй шалгуурыг даван туулахад соёл, бүтээлч байдал болон соёлын олон төрөл зүйл маш чухал үүрэг оролцоотой болохыг онцлон тэмдэглэсэн билээ. Соёлын тогтвортой хөгжилд оруулж буй үүргийг ийнхүү хүлээн зөвшөөрсөн нь 2015 онд 10 дахь жилийн ойгоо тэмдэглэх ЮНЕСКО-гийн Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах болон хөхиүлэн дэмжих Конвенцийн утга санаатай мөн дүйцэж байгаа юм.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нийт 140 орон нэгдсэн энэхүү Конвенц нь соёл, соёлын бүтээгдэхүүн хийгээд үйлчилгээний талаарх нийтлэг хандлагыг өөрчилсөн билээ. Конвенц нь мөн түүнчлэн Засгийн газруудын, соёлын олон төрлийн илэрхийллийг хадгалан хамгаалах болон хөхиүлэн дэмжих бодлогыг танилцуулах бие даасан эрхийг нь хүлээн зөвшөөрсөн юм. Үүний сацуу соёлын арга хэмжээ, бүтээгдэхүүн болон үйлчилгээний хоёр талт үндсэн шинжийг (эдийн засгийн болон соёлын хэмжээсүүд) тодотгосон: ажлын орон тоо хийгээд ажлын байр бүрдүүлэх, шинэ мэдлэг (инноваци) болон тогтвортой эдийн засгийн өсөлтөд түлхэц болохоос гадна үүнтэй зэрэгцээд үнэ цэн болоод дүр төрхийг дамжуулах, нийгмийн нэгдмэл байдал ба нийтлэг чанарт дэм өгөх зэрэг болно. Өнөөдөр бид соёлыг нийгэм болон эдийн засгийн тогтвортой байдлын хүч, хүний эрх хийгээд тулгуур эрх чөлөөнүүдийг хөхиүлэн дэмжигч хөдөлгүүр болохынх нь хувьд энэхүү хослолын олон давуу талуудын гэрч нь болж байна.

2030 оны Хөтөлбөр нь олон хүлээлтийг үүсгэж буй бөгөөд ЮНЕСКО-гийн анхны хяналт-шинжилгээний тайлан нь олон арга замаар мэдээллийг цуглуулж, үнэлэн цэгнэж мөн түгээн дэлгэрүүлэх замаар дэлхийн улс орнуудыг тогтвортой хөгжлийн бодлого болон хөтөлбөр рүү чиглэсэн соёлд нэгтгэснээрээ чухал ач холбогдолтой юм. Энэхүү тайлан нь шинэ Хөтөлбөрийн үр ашигтай байдлыг бататгах болон үр нөлөөг дээд зэргээр ахиулах, улс орнуудад зорилгоо тодорхойлж, бодлогын асуудлуудаа шийдэхэд нь туслахаас гадна хүмүүсийн хэрэгцээ, хүсэл зорилготой нийцсэн шинэ шалгуурыг бодож олох зэрэг хэрэгжилтүүдэд цагаа олсон дэмжлэг болж байна.

Тайлан нь одоогийн чиг хандлагууд, холбогдох бодлого тодорхойлогчдын бүгдэд нь тулгарч буй сорилт болон давуу талуудыг, үндэстэн хоорондын шилжилт хөдөлгөөн, туурвин бүтээх эрх чөлөө, олон улсын зах зээлд нэвтрэх эрх, цахим орчин зэрэг орчин цагийн асуудлуудыг хамарсан инновацийн бодлого болон шалгууруудыг жишээтэйгээр өргөн цар хүрээтэйгээр дүгнэн шинжилсэн. Мөн түүнчлэн энэхүү тайлан нь анх удаагаа соёлын салбар дахь нэгдсэн хяналт-шинжилгээний хам хүрээг өөрчлөлт болон шинэчлэлийн санал болгосон үзүүлэлтүүдийг хавсаргасан.

Миний бие Швед Улсын Засгийн Газар болон Шведийн олон улсын хөгжлийн агентлагт тусгайлан талархал илэрхийлэхийг хүсэж байна. Тэдний дэмжлэг нь 1998 оны Стокгольмын хөгжлийн төлөөх соёлын бодлогын талаарх Засгийн Газар хоорондын чуулганаас хойш 20 гаруй жилийн дараа Швед улсаас олон улсын соёлын бодлогын дүн шинжилгээний цар хүрээг тэлэх чиглэлээр үзүүлж буй томоохон хувь нэмэр юм. Хоёр жил тутмын энэхүү анхны тайлан нь соёлын олон төрлийн илэрхийллийг тогтвортой хөгжлийн бүхий л үйл ажиллагааны цөм гэж дүгнэсэн нь маш чухал болсон. Конвенцид нэгдсэн бусад гишүүн орнууд, хандивлагчид болон хөгжлийн түншүүдийн цаашдын дэмжлэгтэйгээр энэхүү тайланг тогтмол үргэлжлүүлэх нь миний зорилго юм.

Соёлын бодлогыг залан чиглүүлэх шинэ хэлэлцүүлэг ба хандлага шаардлагатай байна. Эдгээр нь соёлын бодлого болон менежментийн удирдлагын бүхий л хүрээн дэх бүтэц болон институцийг өөрчлөх итгэл үнэмшлийг дагалдуулах юм. Үүний сацуу эдгээр шинэ хэлэлцүүлэг хийгээд хандлага нь Үндэстний хэмжээний үндэслэлтэй төлөвлөгөө, мэдээлэл цуглуулалт ба дүн шинжилгээ, хяналт болон үнэлгээнээс гадна үндэслэлтэй, хамтын оролцоотой, олонд нээлттэй бодлого боловсруулалтад суурилах хэрэгтэй. Энэ нь Өмнөд-Өмнөд болон гурван талт хамтын ажиллагааг оролцуулсан илүү нэгдмэл хөгжлийн боломжуудыг шаардана. Энэ тайлан нь тэрхүү олон улсын хүчин чармайлтад оруулж буй хувь нэмэр бөгөөд миний бие энэхүү тайлан нь олон оролцогчдод үйл ажиллагаагаа эхлэхэд нь урам болно гэдэгт итгэлтэй байна. Цаг нь болсон.



Ирина Бокова

ЮНЕСКО-гийн Ерөнхий Нарийн Бичгийн Дарга

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, Шинжлэх ухаан ба Соёлын асуудал хариуцсан байгууллага (ЮНЕСКО)

2015 онд хэвлүүлэв.

Плас Де Фонтэной 7, 75352 Парис 07 СП, Франц

© ЮНЕСКО 2015



Энэхүү хэвлэлтэд хандах боломж нээлттэй: (CC-BY-SA 3.0 IGO) зөвшөөрөл (<http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/>). Хэрэглэгчид энэхүү хэвлэлтийн агуулгыг ашиглахдаа ЮНЕСКО-гийн Нээлттэй Хандалтын Сангийн хэрэглэх нөхцлийг хүлээн зөвшөөрөх шаардлагатай (www.unesco.org/open-access/terms-use-ccbysa-en).

Хэвлэлтэд дурдсан тэмдэглээнүүд болон материалын танилцуулга нь ЮНЕСКО-гийн аливаа улс, бүс нутаг, хот эсхүл газар нутаг, түүний удирдлагуудын эрхзүйн статус юм уу түүний хил, хязгаар, заагтай холбоотой ямар ч үзэл бодлын илэрхийллийг дам агуулаагүй.

Энэхүү хэвлэлтэд илэрхийлж буй үзэл бодлууд болоод санаанууд нь зохиогчдынх бөгөөд тэдгээр нь заавал ЮНЕСКО-гийнх байх албагүй.

Гэрэл зургууд:

Хавтас © Ан Сан Су, 559 дахь удаагийн Хангүл өдрийн зурагт хуудас, 2005 он, БНСУ

x.5 © Чихару Шиота, Гарт буй түлхүүр, 56 дахь удаагийн олон улсын урлагийн үзэсгэлэн - Венецийн биенналийн Япон улсын павильон, 2015 гэрэл зургийг Сунни Манг, Итали/Япон

x.8 © Тадаши Кавамата, Торонтогийн Гарден тауэр, 2013, гэрэл зургийг Жакман Чиу, уран бүтээлчийн өмч, Парис, Франц

x.9 © Мартин Дойон, Монреалийн жүжиг, 2012, Канад

x.10 © Эд Янсэн, Мариска Дэ Грут, Диетер Вандорэн, Сүүдрэн хүүхэлдэй, 2013, Нидерланд

x.11 © В.Паул Виртуцио, Бүжгийг хувьсгалууд, Миннесотагийн их сургууль, 2009, АНУ

x.12 © Чихару Шиота, Цугларал – Очих газраа хайсан нь, 2012, гэрэл зургийг Сунни Манг, Япон

x.13 © Гари Найт, Аддербелигийн тасалбарын цэг, 2014, Их Британи

x.14 © Катерин Маринэ, 2010, Франц

x.15 © Санна Канисто, Хувийн цуглуулга, 2003, Финлянд

x.16 © Лэандра Хаса, Дэ Пласагийн нийгэмлэг, Аргентин

x.17 © Куми Ямашита, Хотын зураглал, 2003, Япон

x.18 © Эд Янсэн, Арнэ Куайнз - Нил цэцгийн Үүр, 23 - 3 -12 (ойрын зураг), 2012, Нидерланд

x.19 © Хаймэ Рохо, Эл Анатуци "Таталцах хүч ба нигүүлсэл"-ийг хоёуланг нь Нью Йоркт толилуулж байна, Бэх таталбар, 2013, АНУ/Гана

© Арабын соёл урлагийн сан, Оссама Халал, "Тэгээс дээгүүр", 2014, Сири

x.20 © Плурал | Катарина М.Рэйнолд, Стивэн Вучер

График дизайн ба хавтасны дизайн: Коринн Хэйворт

ЮНЕСКО-оос эрхлэн хэвлүүлэв.



Швед улсын дэмжлэгтэйгээр хэвлэгдэв.

CLT-2016/WS/2



ЮНЕСКО-гийн Бээжин дэх Төлөөлөгчийн газар Монгол хэлнээ хөрвүүлэх төслийн зохицуулагчаар ажиллав.



Энэхүү номыг 2016 онд ЮНЕСКО-гийн санхүүжилтээр СУИС-иас эрхлэн монгол хэлнээ хэвлүүлэв.

Ерөнхий тойм

Энэхүү тайлан нь 14 бие даасан шинжээч, Конвенцийн Нарийн бичгийн дарга болон, Ерөнхий редактор Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах болон хөхиүлэн дэмжих Конвенцийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн ажлуудыг танилцуулах болно. Тайлангийн зорилго нь 2011 оны Конвенцийн гишүүн орнуудын Чуулганаар баталсан дөрвөн жил тутмын тайлангийн механизмын дагуу Конвенцийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний үйл явцыг үргэлжлүүлэн ахиулахад оршино. Тайланд хувь нэмрээ оруулагсад гишүүн орнуудаас ирсэн 71 тайланд зөвлөгөө өгөхөөс гадна албан бус, бусад эх сурвалжийн мэдээллийг ашиглаж, өөр өөрсдийн мэргэшсэн салбарынхаа хүрээнд ажилласан.

Конвенцийн нарийн бичгийн дарга нарын танилцуулга нь тайлангийн зорилгуудыг тайлбарлах ба Конвенцийн суурь зарчмууд болон үнэт зүйлсээс гадна Конвенцийн урт хугацааны үр нөлөөг хянах аргачлалын гол шугамыг танилцуулах болно. Танилцуулгын дараа анх 1960-аад оны сүүлээс ЮНЕСКО-гийн хүчин чармайлтаас эхтэй, сүүлийн 50 жилийн соёлын бодлогын судалгаа ба үнэлгээний хүрээнд одоогийн нөхцөл байдал, гүйцэтгэлд хийсэн шинжээчдийн үнэлэлт-дүгнэлт залгах бөгөөд тайлан нь 'дэлхий нийтийн соёлын бодлогын судалгааны дэвшлийн гол ололт' гэсэн санааг анхаарч үзнэ. Хоёрдугаар бүлэг нь Конвенцийн хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүдийн системийн үзэл баримтлалын хүрээг санал болгоно. Конвенцийн суурь зарчмуудаас улбаатай дараах 4 хэрэгжилтийн зорилтыг дэвшүүлнэ. Үүнд:

- 1 Соёлын засаглалын тогтвортой системийг дэмжих
- 2 Соёлын бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний тэнцвэртэй урсгалыг бий болгох хийгээд уран бүтээлч болон соёлын мэргэжилтнүүдийн хөдөлгөөнийг нэмэгдүүлэх
- 3 Соёлыг тогтвортой хөгжлийн хамрах хүрээнд нэгтгэх
- 4 Хүний эрх болоод суурь эрх чөлөөг хөхиүлэн дэмжих

Хэсгүүд дээр дурдсан дарааллын дагуу үргэлжлэх болно. Анхны бөгөөд тэргүүний зорилт нь **соёлын засаглалын тогтвортой системийг дэмжих** агаад энэхүү сорилт нь эхний хэсгийг бүрдүүлэгч 4 бүлэгт анхаарлаа хандуулна. Эдгээр бүлгийн эхний хэсэг нь соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хөхиүлэн дэмжих бодлого хийгээд шалгуурт чиглэнэ. Энэ нь гишүүн орнууд соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээнүүдийн бүтээмж, үйлдвэрлэл, тархалт, түгээлт ба таашаалын нэмүү өртгийн гинжин хэлхээг бэхжүүлэхэд улам ихээр зорих болсныг цохон тэмдэглэдэг. Технологи нь шинэ дуу хоолой ба авьяаст шинэ сувгуудыг нээн өгөхийн хажуугаар иргэний оролцооны шинэ хэлбэрүүд нь нэмүү өртгийн гинжин хэлхээн дэх соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээ хоорондын заагийг дахин тодорхойлж, шинэ бодлого болон шалгуурыг загварчлан боловсруулахтай холбоотой шинэ асуултуудыг тавьдаг. Гэвч зарим гишүүн орон өөрсдийн бодлого болон шалгуурын тайландаа 2005 оны Конвенцийн чиг үүрэгтэй хамааралгүй соёлын өвийн гэх мэт сэдвүүдийг тусгасаар байна. Хэдийгээр олон гишүүн орон үүний үр дүнд өөрсдийн соёлын бодлогыг шинэчилж, дахин боловсруулж, шинэ шалгуур болон механизмыг нэвтрүүлсэн авч Конвенцийн их санаачлага шаардсан зорилтуудыг биелүүлэхийн тулд улам их ахиц дэвшилт хэрэгтэй. Тодруулбал, бодлогын хяналт болон үр дүнгийн хэрэгжилтэд зориулж бүрэн үндэслэл боловсруулахын тулд иргэний нийгэм болон төрийн салбарын мэргэжилтнүүдийн хоорондын оролцооны загварыг бий болгох шаардлагатай.

2 дугаар бүлэг нь олон нийтийн хэвлэл мэдээллийн (медиа) чиглэлд буюу өндөр чанартай соёлын агуулгыг үйлдвэрлэгч, захиалагч, түгээгчид болон зохицуулагч нарт зориулагдана. Хэвлэн нийтлэх эрх чөлөөгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон төрөл зүйл оршин тогтнохгүй. Иймээс, мэдээллийн эрх чөлөөний хуулиуд болон тэдгээрийн үр дүнтэй хэрэгжилт маш чухал. Үүнээс гадна цахим сүлжээ болон онлайн орон зайд гарч буй ахиц дэвшилт нь онлайн эрх чөлөөг чухалчлахад сайнаар нөлөөлж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах боломжид гарсан огцом үсрэлт болон түүний сонголт олширсон нь хэвлэл мэдээллийн агуулга нь түүнийг дамжуулж буй зах зээл, гарц чөлөөтэй гэсэн үг биш юм. Цаашлаад хэвлэл мэдээллийн хэрэгслийн орон зай тэлж: дангаараа агуулгын төрөлжилт болон илэрхийллийн баталгаа болж чадахгүй. Технологи нь шинэ дуу хоолой, авьяаст шинэ сувгуудыг нээн дэлгэснээр иргэний сэтгүүлчид болон сонирхогчийн кино үйлдвэрлэгч нарт сэтгүүлзүйн хил хязгаарыг дахин тогтоох боломж олгосон бөгөөд энэхүү чиг хандлагыг дэмжих шаардлагатай. Энэхүү шинэ дуу хоолойн дунд эмэгтэйчүүдийн орон зай бий боловч хүйсийн эрх тэгш байдал хэвлэл мэдээллийн агуулга болоод бодлого төлөвлөлтийн түвшинд төдийлөн ахиагүй бөгөөд эмэгтэйчүүд их бага амар нэг байдлаар гадуурхадсан хэвээрээ байна. Иймээс энэхүү нөхцөл байдлыг сайжруулах алхмуудыг зайлшгүй хийх шаардлагатай.

Технологийн хувьсгал хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон соёлын нэмүү өртгийн гинжин хэлхээний бүхий л түвшинд маш гүн гүнзгий нөлөөлсөн бөгөөд тиймээс 3 дугаар бүлэг нь хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй

цахим орчны утга учир, үр нөлөөг авч үзэх болно. Хөгжиж буй орнууд хөгжилтэй орнуудын цахим орчинд нэвтрэх боломж, түүнийг хүртэн таашаах түвшинд очихоос өмнө олон зүйлийг хийх шаардлагатай. Сүүлийн 10 жилд ялангуяа үүрэн сүлжээний холбоонд маш том ахиц гарсан. Маш олон бүтээн туурвигчид онлайн агуулгыг бий болгохын тулд шинэ технологийг ашиглаж байна. Цахим худалдаа маш хурдацтай өргөжин тэлж байна. Энэ нь хэдийгээр орон нутгийн соёлын үйлдвэрлэлд давуу тал байж болох ч жижиг-дунд үйлдвэрлэлийн тоглогчид томоохон орон зайн тоглогч нарт давуу талыг олгох эрсдэлийг дагуулдаг. 2004 оноос хойшхи нийгмийн сүлжээний огцом өсөлт нь иргэний нийгмийн оролцоонд тэр тусмаа соёлын агуулгын солилцоонд аз завшаан авчирсан.

Конвенц нь түүний хэрэгжилтэд иргэний нийгмийн оролцогчдын хувь нэмрийг оруулсан ач холбогдлоороо шинийг санаачилсан олон улсын хэлэлцээр юм. 4 дүгээр бүлэг нь энэхүү цар хүрээг задлан шинжилнэ. Тайлангийн хамгийн чухал ололтуудын нэг нь гишүүн орнуудын дийлэнх олонхи нь бодлого боловсруулах явцдаа иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулсан явдал юм. Гэсэн хэдий ч Засгийн газрууд болон иргэний нийгмийн байгууллагуудын аль алиных нь үр дүнтэй хамтран ажиллах чадамжид зарим нэг алдаа дутагдлууд бий. 4 жил тутмын тайланг бэлтгэхэд хэдийгээр олон иргэний нийгмийн байгууллагууд оролцсон авч илүү олон иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо шаардлагатай байна. Иргэний нийгмийн "соёлын хоточ нохой"-ны үүрэг нь шаардлагатай хэмжээнд хөгжиж чадаагүй авч өдгөө нийт 43 оронд үйл ажиллагаа явуулж буй Соёлын олон төрөл зүйлийн Үндэстний Нэгдэл дутагдаж буй орон зайг нөхөх тал дээр чухал хөдөлгөх хүч болох боломжтой.

Тайлангийн 2 дугаар хэсэг нь дэлхий нийтээр соёлын бараа бүтээгдэхүүн ба **үйлчилгээний тэнцвэртэй урсгалыг бий болгох хийгээд уран бүтээлч болон соёлын мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөнийг нэмэгдүүлэх** зорилттой холбоотой. Уран бүтээлч болон бусад соёлын мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөн (5 дугаар бүлэг) нь үзэл бодол, үнэ цэн болон ертөнцийг үзэх үзлийн олон төрөл байдлыг хадгалан хамгаалах талаасаа маш чухал юм. Уран бүтээлчид болон соёлын мэргэжилтнүүдийн олон улсын зах зээлд нэвтрэх боломж нь цаашлаад тогтвортой соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжихэд, тэдгээрийн хүн, нийгэм ба эдийн засагт оруулж буй боломжит хувь нэмэрт маш чухал ач холбогдолтой. Хэдий тийм боловч Конвенцийн зарчим болон үзэл санааны хооронд хөгжиж буй орнуудын уран бүтээлч болон соёлын мэргэжилтнүүдийн хөдөлгөөн шилжилтийн тухайд томоохон ялгаа бий. Тухайлбал хөгжилтэй орнуудын аюулгүй байдал, эдийн засаг-улс төрийн хязгаарлалтууд гол бэрхшээл болж Конвенц нь дээр дурдсан хязгаарлалтуудыг даван туулахад ашиг тусгаа өгөх учиртай.

6 дугаар бүлэг нь соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний урсгал болон эдгээрийн тэгш, тэнцвэрт байдал хараахан бүрдээгүй тухай шинжлэн дүгнэх болно. 2004-2013 онуудад хөгжиж буй орнуудын соёлын бараа бүтээгдэхүүний экспортын нийт хэмжээ зогсолтгүй өсөж байгаа бөгөөд тэр тусмаа дүрслэх урлагийн салбарт хөгжиж буй орнуудаас хөгжилтэй орнуудад нийлүүлж буй импортын нийт хэмжээ ойролцоогоор хоёр дахин өссөн үзүүлэлттэй байна. Дээр дурдсан хугацаанд хөгжиж буй орнуудаас хөгжилтэй орнууд руу цөөн тооны мюзикл ба дуу-дүрсийн бараа бүтээгдэхүүнүүд импортлогдсон бол харин ном болон хэвлэлийн бараа бүтээгдэхүүний импортын нийт хэмжээ өсчээ. Хэдий тийм боловч дуу-дүрсийн хэвлэл мэдээлэл гэх мэт соёлын үйлчилгээний урсгалыг хөгжилтэй орнууд эзгнэсэн хэвээр байна. 2004 онд АНУ соёлын үйлчилгээний олон улсын нийт экспортын 58%-ийг, 2012 онд 52.4%-ийг эзэлсэн байдлаар жагсаалтыг тэргүүлж байна. Үлдсэн хувиудыг Европ болон Хойд Америк тивийн хөгжилтэй орнууд эзэлж байна. АНУ-ын дуу-дүрс ба түүнтэй холбоотой үйлчилгээ хийгээд дахин үйлдвэрлэж болох эрхийн чиглэлээр, хөгжиж буй орнуудад хийсэн экспортын нийт хэмжээ 2004-2013 онуудад 11.34%-иас 20.28% болтлоо нэмэгджээ. Дурдсан хугацаанд Өмнөд Америк тивийн АНДЕАН (ANDEAN) нэгдлийн гишүүн орнууд хоорондын соёлын бүтээгдэхүүний экспорт бага зэрэг өссөн (12.3%-18%) бол Пан-Арабын худалдааны чөлөөт бүсийн (PAFTA) гишүүн орнууд хоорондын худалдаа 15%-58% болтлоо өсчээ. Харин Баруун Африкийн орнуудын Эдийн засгийн холбоо (ECOWAS) болон Өмнөд Азийн худалдааны чөлөөт бүсийн хэлэлцээрийн (SAFTA) гишүүн орнууд хоорондын соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний хувь үл ялиг өөрчлөгдсөн байна.

Соёлын олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах болон хөхиүлэн дэмжих нь Конвенцийн ялангуяа худалдааны салбар дахь бусад олон улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй гэрээ хэлэлцээрүүд дэх нөлөөллөөс хамааралтай. Дараагийн буюу 7 дугаар бүлэг дээр дурдсан асуудлыг хамрах агаад Европын Холбооны 2005 оноос баталсан худалдааны чиглэлийн 7 хэлэлцээр нь Конвенцтой 1 хийгээд нижгээд байдлаар шууд харилцан хамааралтайг олж тогтоосон. Түүнээс гадна худалдааны гэрээ хэлэлцээрүүдийн "соёлын чөлөөлөлт"-ийн шалгуурт зарим нэг соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээг оруулахгүй байх чиглэлээр ахиц гарсаар байна. Цаашлаад Соёлын хамтын ажиллагааны Тогтоол нь худалдааны гэрээ хэлэлцээрүүдийн бүрэлдэхүүнд орохдоо соёлын үйлчилгээ болон худалдааны тодорхой шинжүүдийг (мөн түүнчлэн ялангуяа хөгжиж буй орнуудын уран бүтээлч болон соёлын мэргэжилтнүүдэд давуу эрх олгох боловсруулалтыг тусгасан) хүлээн зөвшөөрсөн. Худалдааны чиглэлийн гэрээ хэлэлцээрүүдээс гадна Конвенц нь 2005 оноос хойш нийт 250 гаруй олон улсын, бүс нутгийн болон хоёр талын хамтын ажиллагааны байгууллагуудын баримт бичгүүдэд ишлэл болон ашиглагдаж байна.

8 дугаар бүлэг нь соёлын тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөгөө ба хөтөлбөрүүд хэрхэн эерэг нөлөө үзүүлснийг (хэдийгээр тодорхой ахиц дэвшил гарсан авч соёлыг тогтвортой хөгжлийн хамрах хүрээнд нэгтгэх чиглэлээр олон бэрхшээл байсаар байгаа) үнэлж дүгнэх болно. Энэхүү бүлэг нь мөн түүнчлэн соёлын болон бүтээлч үйлдвэрлэл нь эдийн засгийн болоод соёлын талаасаа тогтвортой хөгжлийн нэг чухал бодлогын зорилт байх ёстой гэсэн санааг авч хэлэлцэнэ. Донор орнуудад өөрсдийн Албан ёсны Хөгжлийн Тусалцааны (ODA) стратеги болон хөтөлбөрүүдээрээ дамжуулан дээрх зорилтыг хөхиүлэн дэмжих чамгүй бололцоо бий. Энэ чиглэлийн бүхий л санал санаачлагууд нь бодлого боловсруулагчдад хөгжлийн талаар хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө соёлын асуудлыг оруулж хүлээн зөвшөөрөхөд нөлөөлөх, Үндэстний нийгэм-эдийн засгийн зорилго зорилтуудыг хэрэгжүүлэхэд соёлын болон бүтээлч үйлдвэрлэл эрчтэй үүрэг оролцоотойг ойлгуулахад оршино. Соёлын тогтвортой хөгжлийн суурь зарчмуудын нэг нь нийгмийн эмзэг бүлэгт тэгш хандах явдал бөгөөд энэхүү зарчимд анхаарлаа хандуулах нь зөвхөн соёлын оролцоонд хамрагдах боломжид тулгардаг давуу бус байдлыг засч залруулах стратегийг шаардахаас гадна бусад салбар дахь соёлын бодлого нь санамсаргүй сөрөг харш нөлөөг үүсгэхгүй байхад сонор сэрэмжтэй байхыг шаарддаг.

Энэхүү тайлангийн сүүлчийн хэсэг нь хэдийгээр Конвенцийн хэрэгжилтэд одоог болтол төдийлөн урьтал болдоггүй ч Конвенцийн салшгүй нэгээхэн зарчим болох **хүний эрх болоод суурь эрх чөлөөнүүдийн илэрхийлэл**, мэдээлэл болон харилцаа холбоог хөхиүлэн дэмжихэд зориулагдсан. Ялангуяа хүйсийн тэгш байдал бол түлхүүр асуудал бөгөөд Конвенцийн хувьд соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээний эмэгтэй үйлдвэрлэгч ба уран бүтээлчдийг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн дэмжсэн, хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого болоод шалгуурыг дэмжихийг маш ойлгомжтойгоор тусгасан. 9 дүгээр бүлэг нь хүйсийн тэгш байдлыг хэлэлцсэн бөгөөд тухайлбал хэдийгээр эмэгтэйчүүд дэлхийн орнуудын бүтээлч салбарт хүчтэй орон зайг эзэлж буй авч соёлын мэргэжил хийгээд бодлого гаргах түвшинд хангалтгүй хувийг эзэлсээр байгааг тэмдэглэсэн. Энэхүү төлөв байдал нь соёлын олон төрөл зүйлийн ач холбогдлыг бууруулаад зогсохгүй уран бүтээлч хамт олон болон салбарт саадгүй нэвтрэх чадамж бүхий бүтээлч эмэгтэйчүүдийн талд нь саад тотгор учруулж байна. Олон орон эмэгтэйчүүдэд боломж олгох болон цаашлаад эмэгтэйчүүдийн хөдөлгөгч хүчний бүтээлч эдийн засагт оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсаар байна. Гэвч соёлын салбарт хүйсийн тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлага хангалттай түвшинд шийдэгдээгүй л байна. Үүнд нөлөөлж буй хамгийн том саад тотгор бол хүйсээр ялган харуулсан тоо баримт хангалтгүй байгаа явдал юм. Хүйсийн тэгш байдал, соёлын эрх болон соёлын олон төрөл зүйл хоорондын хосолмол харилцааг хүлээн зөвшөөрсөн нэгдмэл хандлага нь мөн түүнчлэн чухал ач холбогдолтой.

Төгсгөлийн буюу 10 дугаар бүлэг нь уран бүтээлийн эрх чөлөөний сэдэвт чиглэсэн агаад энэ нь зөвхөн уран бүтээлчид хийгээд тэдний бүтээлч үйл ажиллагаанаас гадна бүхий л соёлын үйлдвэрлэгчдийн эрхтэй мөн хамаатай. Энэ нь суурь эрх чөлөөний цар хүрээ бөгөөд бүхэлдээ иргэд, нийгмийн сайн сайхан амьдралын салшгүй нэг хэсэг юм. Энэ бүлэг нь уран бүтээлийн эрх чөлөө болон түүнийг хүртэх боломжийг хязгаарлахад хүргэж буй төрийн болон төрийн бус нөлөө, түүний оролцоог задлан шинжилнэ. Мөн түүнчлэн гишүүн орнуудын болон бусад оролцогчдын энэхүү хүрэн дотор цохон дурдсан зарим шалгуурыг нягтлах бөгөөд ингэснээр аюултай байдалд буй уран бүтээлчдэд дэм үзүүлнэ. Цаашлаад уран бүтээлийн илэрхийлэл ба бүтээлч байдалд зайлшгүй шаардлагатай эрх чөлөө нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний Эрхийн Хорооны 2013 оны 03-р сард хэвлүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын анхны Илэрхийллийн Эрх Чөлөөний тусгай Тайлангийн сэдвүүд байсныг онцлон дурддаг.



Тайлангийн эцсийн дүгнэлт нь гол дүгнэлтүүдийг дахин нэгтгэн үнэлж цэгнэх ба цаашдын арга замыг тодорхойлно. 2005 оны Конвенц нь зарим гишүүн орон Конвенцийг хэрэгжүүлэхээс өмнө аль хэдийнэ сайн тодорхойлсон соёлын бодлогын хамрах хүрээтэй байсан ч бай соёлын илэрхийллийн олон төрөл зүйлд үр ашиг өгөх бодлого боловсруулалтыг бүхэлд нь сайжруулсан нь илэрхий. Гэвч Конвенцийн хэрэгжилтийн зайлшгүй шаардлагууд нь шинэ хамрах хүрээ юм уу, механизмын хөгжил рүү эргэлзээгүйгээр хөтлөн аваачсан. Энэхүү давуу талууд болон шинэ мэдлэг (инноваци) нь итгэл найдвар төрүүлэхүйц боловч хангалттай бус юм. Илүү ололт дэвшилтэд хүрэх шаардлага байна. Ойрын ирээдүйд хяналт, шинжилгээ, үнэлгээг илүү утга учиртай болгохын тулд сургамжийг тусгаж, нэн ялангуяа мэдээлэл цуглуулах, үзүүлэлт бий болгох тал дээр санал боловсруулж ажиллаваас энэхүү ололт дэвшилт нь сайн зүйл хэмээн нийт оролцогч талууд үзэж байна.

**СОЁЛЫН ОЛОН ТӨРӨЛТ ИЛЭРХИЙЛЛИЙГ ХАДГАЛАХ ХАМГААЛАХ БОЛОН ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ
2005 ОНЫ КОНВЕНЦИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ**

**БАРИМТЛАХ
ЗАРЧМУУД**

Ил тод, нээлттэй болон оролцооны үйл явц хийгээд засаглалын тогтолцоонд суурилан соёлын илэрхийллийн төрөл зүйлийг хөхиүлэн дэмжих бодлогыг хэрэгжүүлэх, хүлээн зөвшөөрөх нь Улс орнуудын өөрсдийн бүрэн эрх нь баталгаажсан байна.

ЗОРИЛГО

СОЁЛЫН ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ ТОГТОЛЦООГ ДЭМЖИХ

**ГАРАХ ҮР
ДУН**

Үндэсний бодлого ба шалгууруудын хэрэгжилт нь соёлын олон төрөл зүйлийн бүтээгдэхүүн ба үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх, түгээх болон хүртэх эрхийг хөхиүлэн дэмжих, улмаар ил тод, нээлттэй хийгээд оролцооны соёлын засаглалын тогтолцоонд хувь нэмрээ оруулахад чиглэнэ

**ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭНИЙ
ХАМРАХ ХҮРЭЭ**

Соёлын бодлого

*Олон нийтийн
мэдээллийн
хэрэгсэл*

Цахим орчин

*Иргэний нийгмийн
түншлэл*

Үндэсний соёлын бодлого нь соёлын төрөл зүйлийн бүтээгдэхүүн ба үйлчилгээг бүтээх, үйлдвэрлэх, түгээх болон хүртэхэд дэмжлэг үзүүлдэг

Эрх зүйн суурь нь хэвлэл мэдээллийн эрх чөлөө хийгээд төрөл зүйлийг хөхиүлэн дэмждэг

Эрх зүйн суурь нь интэрнэтэд нэвтрэх дэлхий нийтийн боломжийг дэмждэг

Эрх зүйн болон санхүүгийн суурь нь иргэний нийгмийг хөхиүлэн дэмждэг

ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бодлого боловсруулалтад Засгийн газрын олон агентлагууд оролцдог

Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн зорилго хууль эрх зүйн хувьд тодорхойлогдсон баталгаажсан байдаг

Цахим бүтээлч байдал болон цахим орчинд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэхийг бодлого, шалгуураар хөхиүлэн дэмждэг

Бодлого боловсруулалт болон бодлогын хэрэгжилтэд иргэний нийгэм оролцдог

Гишүүн орнууд мэдээлэгдсэн бодлого боловсруулах үйл явцыг идэвхитэй дэмждэг

Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийн бодлого болон хэрэгжүүлж буй алхмууд нийгмийн бүхий л бүлгийн эрх ашигт үйлчилдэг

Хөдөлгөөнтэй олон төрөл зүйлийн цахим соёлын үйлдвэрлэлийн зах зээлийг хөхиүлэн дэмжсэн бодлого, үйл ажиллагаагаар дэмждэг

Конвенцийг соёрхон батлах хөхиүлэн дэмжихэд иргэний нийгэм идэвхитэй оролцдог

<p>Соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээнүүдийн урсгалыг эрх тэгш хүртэх эрх, ил тод болон тэнцвэртэй байдал, уран бүтээлчид болон соёлын мэргэжилтнүүдийн чөлөөт шилжилт хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх</p>	<p>Тогтвортой хөгжлийн эдийн засаг болон соёлын цогц байдлыг хүлээн зөвшөөрсөн</p>	<p>Хүний эрх болон суурь эрхүүдийн илэрхийлэл, мэдээлэл ба харилцаа холбоог хүндэтгэн дээдлэх нь соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг бүтээх, түгээн дэлгэрүүлэх урьдчилсан нөхцөл болохынхоо хувьд баталгаажсан</p>
<p>СОЁЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН БА ҮЙЛЧИЛГЭЭНҮҮДИЙН УРСГАЛЫН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАХ, УРАН БҮТЭЭЛЧИД БОЛОН СОЁЛЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ</p>	<p>СОЁЛЫГ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭНД НЭГТГЭХ</p>	<p>ХҮНИЙ ЭРХ ХИЙГЭЭД СУУРЬ ЭРХҮҮДИЙГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ</p>

Соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээнүүдийн тэнцвэртэй урсгал болон дэлхий нийтийн уран бүтээлчид ба соёлын мэргэжилтнүүдийн хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийг урьтал болгон хэрэгжүүлдэг

Тогтвортой хөгжлийн бодлого ба олон улсын туслалцааны хөтөлбөрүүд соёлыг стратегийн хэмжигдэхүүн хэмээн нэгтгэж авч үздэг


Хүний эрх хийгээд суурь эрхүүдтэй холбоотой олон улсын болон үндэсний хууль тогтоомж хэрэгждэг бөгөөд уран бүтээлчдийн бүтээн туурвиж, нийгэм-эдийн засгийн эрхийг хоёуланг нь хөхиүлэн дэмждэг

<p>Уран бүтээлчид болон соёлын мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөн</p>	<p>Соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээний урсгал</p>	<p>Гэрээ ба хэлэлцээрүүд</p>	<p>Үндэсний тогтвортой хөгжлийн бодлого ба төлөвлөгөөнүүд</p>	<p>Олон улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүд</p>	<p>Хүйсийн эрх тэгш байдал</p>	<p>Бүтээн туурвих эрх чөлөө</p>
<p>Эрх зүйн суурь нь шилжилт хөдөлгөөнийг баталгаажуулдаг</p>	<p>Эрх зүйн суурь нь соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээний урсгалыг дэмждэг</p>	<p>Гишүүн орнууд нь Конвенцийн зорилго, зарчмуудыг бусад чуулга уулзалтуудад хөхиүлэн дэмждэг</p>	<p>Соёл нь үндэсний тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бүрэлдэхүүн хэсэг болдог</p>	<p>Соёл нь олон улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсэг болдог</p>	<p>Эрх зүйн орчин нь соёлын салбар дахь хүйсийн тэгш байдлыг баталгаажуулдаг</p>	<p>Эрх зүйн суурь нь илэрхийллийн эрх чөлөөг дэмждэг</p>
<p>Бодлого, үйл ажиллагаагаар хөгжиж буй орнуудаас ирэх шилжилт хөдөлгөөнийг дэмждэг</p>	<p>Бодлого, үйл ажиллагаагаар соёлын бүтээгдэхүүнүүдийн олон улсын урсгалыг дэмждэг</p>	<p>Конвенцийг олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлэлцээрүүдэд ил тодоор ишлэгддэг</p>	<p>Соёлын нөөцийн хуваарилалтад бүс нутгийг эрх тэгш байдалтай оролцуулахыг бодлого, үйл ажиллагаагаар дэмждэг</p>	<p>Техникийн туслалцааны хөтөлбөрүүд нь хөгжиж буй орнуудын соёлын ба бүтээлч үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийн чадварыг дээшлүүлдэг</p>	<p>Эмэгтэйчүүдийг соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээний бүтээгч ба үйлдвэрлэгчийн хувьд бодлого, үйл ажиллагаагаар дэмждэг</p>	<p>Бодлого үйл ажиллагаагаар уран бүтээл туурвих эрх чөлөөг хадгалан хамгаалж, хөхиүлэн дэмждэг</p>
<p>Төрийн бус санаачилгууд хөгжиж буй орнуудаас ирэх шилжилт хөдөлгөөнийг дэмждэг</p>	<p>Бодлого үйл ажиллагаагаар соёлын үйлчилгээнүүдийн олон улсын урсгалыг дэмждэг</p>	<p>Бодлого, үйл ажиллагаагаар Конвенцтой хамаатай олон улсын болон бүс нутгийн гэрээ хэлэлцээрүүдийг хэрэгжүүлдэг</p>	<p>Нийгмийн эмзэг бүлэг, соёлын нөөцийг эрх тэгш хүртэх боломжийг бодлого, үйл ажиллагаагаар дэмждэг</p>	<p>Хөгжиж буй орнуудын бүтээлч байдлыг дэмжин санхүүгийн туслалцаа үзүүлдэг</p>	<p>Бодлого үйл ажиллагаа нь эмэгтэйчүүдийн соёлын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн болон үйлчилгээг хүртэх эрх, боломжийг дэмждэг</p>	<p>Бодлого үйл ажиллагаа нь уран бүтээлчдийн нийгэм болон эдийн засгийн эрхийг дэмждэг</p>



Бүс нутгийн түвшинд 4 жил
тутмын тайлангаа илгээсэн
гишүүн орнуудын хувь хэмжээ
(2012-2014)

Эх үүсвэр: QPRs



Нэгдүгээр бүлэг

Бодлого төлөвлөлтийн шинэ чиг хандлагууд

Нина Обулжен Коржнек

ГОЛ САНААНУУД

- >>> Соёлын бодлого ба шалгуурууд нь бүтээх, үйлдвэрлэх, түгээх болон түүнийг хүртэх эрхийн нэмүү өртгийн гинжин хэлхээг нэмэгдүүлэхийг улам ихээр зорьж байна.
- >>> Конвенцийн нэг давуу тал нь Соёлын яамдын шалгуур, механизмаас ондоо шалгуур болон механизмуудыг хамарсан соёлын бодлогын ойлголтыг дэлгэрүүлсэн явдал юм.
- >>> Соёлын бодлого ба шалгууруудыг тайлагнах үйл явц нь Конвенцид нэгдсэн гишүүн орнуудын одоогийн мэдээлэл, харилцаа холбооны системийг боловсронгуй болгож байна.
- >>> Иргэний нийгэм болон нийтийн үйлчилгээний мэргэжилтнүүд хоорондын оролцооны загвар нь бодлогын хяналт ба үр дүнгийн үнэлгээний даацтай үндэслэлийг шаарддаг.
- >>> Дийлэнх гишүүн орнууд тайландаа өөрсдийн соёлын бодлогын шинэчлэл болон Конвенцийг хүлээн зөвшөөрсний үр нөлөөгөөр шинээр хэрэгжүүлсэн шалгуур ба механизмуудыг дурдсан хэдий ч Конвенцийн санаачлагууд бүхий зорилгуудыг биелүүлэхийн тулд улам их ахиц дэвшил шаардлагатай байна.



Бидний хамгийн том үнэт зүйл бол манай иргэдийн авьяас бөгөөд бидний ажлын утга учир нь тэрхүү авьяасыг гэрэлтүүлэн гялалзуулах боломжийг бий болгох явдал юм. Бид боловсролыг нийгмийн өөрчлөлтийн хөдөлгүүр болгодог агаад боловсролыг шинжлэх ухаан, технологи, интерпренершип, шинэ мэдлэг (инноваци), спорт ба соёл гэсэн өргөн хүрээнд ойлгодог.

Хууль дүрмийн суурь зарчим болон нээлттэй байдалд тулгуурлан бид нийтийн нөөц баялагт нэвтрэх боломжийг уран бүтээлчид ба соёлын менежерүүдэд уралдаан, нээлттэй дуудлага худалдаа бий болгох байдлаар бүрдүүлж, тэдний бүтээн туурвих, мэргэших, соёлын солилцооны шилжилт хөдөлгөөнд орох ба тогтмол орлоготой байх мөрөөдийг тэтгэлэгт хамрагдах байдлаар хангаж бүрдүүлсэн. Бид Соёл, урлагийн салбарын Зөвлөлүүдийг байгуулах замаар соёлын хөдөлгөөнийг бэхжүүлсэн ба 19067 уран бүтээлч, 88 зөвлөлийн төлөөллийн оролцоотойгоор 2014-2020 оны Соёл, урлагийн салбарын 8 төлөвлөгөөг боловсруулсан. Эдгээр төлөвлөгөө нь бидний Антиокуа руу явах замыг тодорхойлогч замын газрын зургууд юм. Бид бас Меделлинд үүнийг хэрэгжүүлсэн.

Өнөөдөр Антиокуагийн 80 нутгийн захиргааны Боловсролын паркуудыг бид нээснээр нэг дор цуглах, боловсролын үйл ажиллагаа явуулах орон зай бий болж, соёлын арга хэмжээнүүд соёлыг суралцах хийгээд түүгээр дадлагажихыг дэлгэрүүлэн дэмжинэ.

Сержио Фахардо

Колумбийн Антиокуагийн Амбан Захирагч

Хэвлэл мэдээллийн олон төрөл зүйлийг дэмжих шинэ саналууд

Кристин М.Меркел

ГОЛ САНААНУУД


- >>> Ямар технологи, арга хэрэгсэл ашиглагдаас үл хамааран тоймгүй болон өндөр чанарын, амьдрах чадвартай соёлын агуулгын үйлдвэрлэгч, захиалагч, борлуулагч, түгээгч болохын хувьд олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь соёлын илэрхийллийн төрөл зүйлийн амин чухал амьдрүүлэгч болон хөтлөгч нь байх юм.
- >>> Хэвлэл мэдээллийн эрх чөлөө байхгүйгээр хэвлэл мэдээллийн олон төрөл оршин тогтнохгүй. Тиймээс мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон түүний үр дүнтэй хэрэгжилт маш чухал. Цахим сүлжээ болон онлайн орон зайны өсөлт нь үндсээрээ өөрчлөгдсөн хэвлэл мэдээллийн эко-систем дэх цахим эрх чөлөөг хөхиүлэн дэмжих чухал хүчин зүйл болсоор байна.
- >>> Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах боломжид гарсан огцом үсрэлт болон түүний сонголт олширсон нь хэвлэл мэдээллийн агуулга нь түүнийг дамжуулж буй зах зээл, гарц нь чөлөөтэй байна гэсэн үг биш юм. Мөн түүнчлэн хэвлэл мэдээллийн хэрэгслийн олон тооны орон зай нь ч дангаараа агуулгын төрөлжилт болон илэрхийллийн баталгаа нь болж чадахгүй.
- >>> Технологи нь шинэ дуу хоолой, авьяаст шинэ сувгуудыг нээн дэлгэсэн нь иргэний сэтгүүлчид болон сонирхогчийн кино үйлдвэрлэгч нарт сэтгүүлзүйн хил хязгаарыг дахин тогтоох боломж олгосон бөгөөд энэхүү чиг хандлагыг дэмжих шаардлагатай.
- >>> Энэхүү шинэ дуу хоолойн дунд эмэгтэйчүүдийн орон зай бий боловч хүйсийн тэгш байдал хэвлэл мэдээллийн агуулга болоод бодлого төлөвлөлтийн түвшинд төдийлөн ахиагүй бөгөөд эмэгтэйчүүд их бага ямар нэг байдлаар гадуурхагдсаар байна. Тийм учраас нөхцөл байдлыг сайжруулах алхмуудыг хийх зайлшгүй шаардлагатай.



Хэвлэл мэдээлэл дэх соёлын илэрхийллийн олон төрөл зүйл болон бүтээлч байдлыг нэмэгдүүлэхийн тулд нийтийн бодлогын дэмжлэг шаардлагатай бөгөөд ингэснээр шинэ дуу хоолой, санаа болон хандлагын хүрээлэн буй орчинд дэмжлэг үзүүлнэ. Хүн бүр тэнцвэртэй байдлаар өөрсдийн илэрхийллийн эрх чөлөөг хэрэгжүүлэх эрхтэй бөгөөд үзэл санааны солилцоо ба олон нийтийн хэлэлцүүлэг нь ардчиллыг бэхжүүлдэг. Энэ нь дуу хоолойн олон төрөл зүйл хийгээд олон ургалч үзлийг шаардах агаад аливаа хяналтыг үл зөвшөөрч, түүхэн явцад гадуурхагдсан нийгмийн бүлгийг хамруулна. Төр засаг нь дуу-дүрсийн хэвлэл мэдээллийн олон төрөл зүйл хийгээд олон ургалч үзлийг дэмжихийн тулд тодорхой, ил тод зохицуулалтын хамрах хүрээг дэмжих хэрэгтэй. Мөн түүнчлэн харилцаа холбооны 3 гол салбарыг (арилжааны, олон нийтийн ба нийгмийн хэсэг бүлгийн хэвлэл мэдээлэл) хүлээн зөвшөөрч хөхиүлэн дэмжих шаардлагатай. Хэрэв бид дээр дурдсан чиглэлүүдийг хөгжүүлбэл гэвэл илэрхийллийн олон төрөл зүйлийн одоогийн нөхцөл байдал болон тэдгээрийн хэвлэл мэдээлэл дэх төлөөллийг мэдэх нь маш чухал. Үүнд ЮНЕСКО-гийн 2005 оны Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах ба хөхиүлэн дэмжих Конвенцийн анхны Хяналтын Тайлангийн” ач холбогдол оршино.”

Эдисон Ланза

Америк хоорондын Хүний эрхийн Хорооны Илэрхийллийн Эрх Чөлөөний Тусгай Илтгэгч






Дэлхийн дуу бичлэг үйлдвэрлэлийн 2014 оны цахим орлогын хувь хэмжээ

Эх үүсвэр: IFPI, 2015

6.85 ТЭРБУМ АМЕРИК ДОЛЛАР

ДУУ БИЧЛЭГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН 2014 ОНЫ ЦАХИМ ОРЛОГО



3 дугаар бүлэг

Цахим эриний сорилтууд

Октавиа Кулээ

ГОЛ САНААНУУД

- >>> Хөгжиж буй орнууд хөгжилтэй орнуудын цахим орчинд нэвтрэх боломж, түүнийг хүртэн таашаах түвшинд очихоос өмнө олон зүйлийг хийх шаардлагатай.
- >>> Олон тооны бүтээгчид Ютүб, Википедиа болон бусад олон орон зайд онлайн контент бий болгохын тулд шинэ технологиудыг эрчимтэй ашиглаж байна.
- >>> Цахим худалдаа маш хурдацтай өргөжин тэлсэн нь хэдийгээр орон нутгийн соёлын үйлдвэрлэлд давуу тал байж болох ч жижиг-дунд үйлдвэрлэлийн тоглогчид томоохон орон зайн тоглогч нарт давуу талыг олгох эрсдэлийг дагуулдаг.
- >>> 2004 оноос хойших нийгмийн сүлжээний огцом өсөлт нь иргэний нийгмийн оролцоонд тэр тусмаа соёлын агуулгыг солилцох аз завшааныг олгосон.



Цахим үйлдвэрлэл Африкийн хувьд гайхалтай бололцоо агаад одоогоор хөгжлийн эхэн үедээ бойжиж байна. Тиймээс цаг хугацаа, мөнгө болон шинжээчийн дүгнэлт зэрэг их хэмжээний хөрөнгө оруулалтыг шаарддаг. Одоогоор бидэнд шаардагдаж буй зүйл бол гарч ирж буй бүтээлч технологийн салбарт өөрсдийн бүхий л эрч хүчийг дайчилж Африк тивийн цахим хувь тавиланд туслах явдал юм. Бидэнд код бичихийг сурч, өөрсдийн чөлөөт цагаараа технологийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж байгаа нэгэн үеийн залуучууд бий бөгөөд тэдний эзэмшсэн авьяасыг бэхжүүлэх замаар Африк тивийн залуу үеийн нийтлэг цахим ирээдүйг бүтээх зорилгыг тэтгэн дэмжих нь маш чухал.

Тоон систем ба технологи нь ойрын 10 жилийн хамгийн гол хурдасгуур байх нь дамжиггүй. Эдгээр нь хүмүүст соёл, боловсрол, банк, мэдээ мэдээлэл, эрүүл мэнд болон бусад салбарт нэвтрэх боломжийг илүү ихээр олгох болно. Тэр тусмаа бүтээлч үйлдвэрлэл цахим технологиор дамжин бүхлээрээ хувьсан өөрчлөгдсөн. Африкийн үзвэр үйлчилгээний хамгийн танигдсан хэлбэр болох Нолливуд нь интернетгүйгээр дөнгөлөгдсөн, идээ шархандаа баригдсан, зах зээлд VCD-г хууль бусаар борлуулсан тэр байдалдаа л байх байсан. Харин одоо соёлын агуулгыг олон сая хүн сонирхон таашааж, тэрхүү кинонуудыг бүтээгчид нь эцэстээ хийсэн ажлынхаа төлөө шударгаар нөхөн төлбөр хүртэж байна.

Шинэ технологиуд нь Африк тивийг өөр хооронд нь холбох дуу хоолой, арга хэрэгсэл болоод зогсохгүй дэлхийн бусад тивүүдтэй холбох болно.”

Жэсон Нжоку

Ироко Партнэрсийн гүйцэтгэх захирал

Иргэний нийгэмтэй түншлэхүй
Хелмут К.Анхайэр болон Олга Кононихина



Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах болон хөхиүлэн дэмжих 2005 оны Конвенцийг хүлээн зөвшөөрсөн нь Буркино Фасо болон ерөнхийдөө Африк тивийн иргэний нийгэмд итгэл найдварын маш чухал эх үүсвэр болсон. Олон соёлын олон төрөл зүйлийн эвслүүдийг бий болгосон нь соёлын мэргэжилтнүүд болон соёлын байгууллагуудыг улс төрийн тавцанд аваачсан агаад энэ нь зөвхөн тэднийг танцулаад зогсохгүй Буркино Фасо дахь хөтөлбөр, үйл ажиллагаануудын хэрэгжилт болон олон нийтийн мэтгэлцээнд татан оролцуулсан. Буркино Фасо дахь соёлын олон төрөл зүйлийн эвсэл нь хяналтын үүрэг оролцоотой ба мөн түүнчлэн түүнийг боловсронгуй болгох төлөвлөгөөг хэрэгжүүлдэг. Бид удирдлагуудтай хийх яриа хэлэлцээг хир чинээгээрээ дэмжиж, Конвенцийн зарчмууд нь соёлын бодлогыг боловсронгуй болгоход хөтөлж байгаасай гэж хичээдэг. Дэлхий дахины иргэний нийгэм нь энгийн иргэд соёлоос ямар хүлээлттэй байгаа талаар хэлэлцэх хэрэгтэй. Энэхүү Конвенц нь үүнийг хэрэгжүүлэх арга хэрэгслийг бидэнд олгодог бөгөөд энэ боломжийг ашиглацгаая.”

Расманэ Куэдраого


Үндэстний соёлын олон төрөл зүйлийн эвслийн ерөнхийлөгч

ГОЛ САНААНУУД

- >>> *Иргэний нийгэм нь Конвенцийн хэрэгжилтэд идэвхитэйгээр нэгдсэн агаад тэр тусмаа Конвенцийн зорилго хийгээд зарчмуудыг олонд таниулах үйл ажиллагаанд чухал оролцоотой.*
- >>> *Бодлого боловсруулах ба түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр төр-иргэний нийгмийн тогтвортой хамтын ажиллагаа нь хүчтэй сорилтуудтай тулгардаг. Тухайлбал Үндэстний Засгийн Газар, орон нутгийн удирдлага болон иргэний нийгмийн байгууллагуудын идэвхитэй хамтран ажиллах чадамжийн дутмаг байдал, цаашлаад иргэний нийгэм дэх санхүү, чадвартай хүний нөөцийн хүрэлцээгүй байдал, Конвенцийн тухай мэдлэг, ойлголт дутуу зэргийг энд хамааруулж болно.*
- >>> *Олон тооны иргэний нийгмийн байгууллагууд 4 жил тутмын Тайланг бэлтгэхэд оролцсон авч иргэний нийгмийн олон төрөл зүйлийн дуу хоолой дутмаг байгаа хэвээрээ бөгөөд ийм оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.*
- >>> *Иргэний нийгмийн `соёлын хоточ нохой`-ны үүрэг шаардлагатай хэмжээнд хөгжиж чадаагүй боловч өдгөө нийт 43 оронд үйл ажиллагаа явуулж буй Соёлын олон төрөл зүйлийн Үндэстний Эвслүүд дутагдаж буй орон зайг Үндэстний болоод олон улсын түвшинд нөхөх тал дээр чухал хөдөлгөх хүч болох боломжтой.*

2013 оны Иргэний нийгэмд боломж олгодог орчны тоон үзүүлэлт

эх сурвалж: EEI, 2013




БАГА БОЛОМЖ ОЛГОДОГ

ИХ БОЛОМЖ ОЛГОДОГ



Уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөн ба хөгжилд зориулсан нийтийн ба хувийн санхүүжилтийн тоо хэмжээ бүс нутгаар

Эх сурвалж: On the move, 2015



Ялгаанд анхаарлаа хандуулахуй: Хөдөлгөөнийг дэмжих нь Микеван Граан ба София Санан

ГОЛ САНААНУУД

- »»» Уран бүтээлчид болон соёлын мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөн нь ертөнцийг үзэх олон ургалч үзэл санаа, үнэ цэн болон хандлагыг дэлгэрүүлэхэд чухал ач холбогдолтой.
- »»» Уран бүтээлчид болон соёлын мэргэжилтнүүдийн олон улсын зах зээлд нэвтрэх боломж нь цаашлаад тогтвортой соёлын болон бүтээлч үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжихэд, нэн ялангуяа хөгжиж буй орнуудад тэдгээрийн хүн, нийгэм ба эдийн засагт оруулж буй боломжит хувь нэмэрт маш чухал ач холбогдолтой.
- »»» 2005 оны Конвенцийн үзэл баримтлал, туйлын зорилго хийгээд хөгжиж буй орнуудын уран бүтээлчид ба соёлын мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой олон улсын бодит байдлын хооронд асар их ялгаа бий. Үнэндээ Конвенцийн хэрэгжилт нь дээрх шилжилт хөдөлгөөнийг дэмжих тал дээр төдийлөн хувь нэмрээ оруулж чадаагүй байна.
- »»» Хөгжингүй орнууд дахь аюулгүй байдал, эдийн засаг-улс төрийн хязгаарлалтууд уран бүтээлчид болон соёлын мэргэжилтнүүдийн хөдөлгөөнд бэрхшээл учруулдаг. Иймээс дээр дурдсан хязгаарлалтуудыг олон улсын эв нэгдлийн санаан дор, даван туулахад Конвенцийг илүү үр дүнтэй ашиглах шаардлагатай.
- »»» Уран бүтээлчид ба соёлын мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөнийг хөхиүлэн дэмжих мэдээлэл, санхүүжилт болон бусад бололжийг нэг дор цуглуулж, түүнээс гишүүн орнууд хуваалцах шаардлагатай.



Сүүлийн 40 жилийн хугацаанд Арабын бүс нутаг муу засаглалаас болж их хохирлыг амссан. Энэ байдал бүс нутгийг хамарсан улс төрийн дараалсан маргаан болон хүмүүнлэгийн хямралаас үүдэлтэй олон сая хүмүүс нүүн шилжсэн зэрэг хүчин зүйлсээс хамаарч улам хүндэрсэн. Арабын соёл урлагийн сангийн хувьд, оролцоо сайтай, идэвхитэй, нээлттэй соёлын талбар нь ийм үйл явдалд хариу өгч, өөрчлөлт болон сэргэн мандалын бусад хүчнийг олноор бий болоход нөлөөлөн, иргэний нийгэмд гүн гүнзгий хийгээд урт хугацааны өөрчлөлтийг бий болгож чадах юм гэсэн итгэл үнэмшилтэй байна. Гэсэн хэдий ч олон төрөл зүйл, нээлттэй ба хүлээцтэй байдлыг дэмжих соёл хоорондын хамтын ажиллагаа нь чөлөөт илэрхийлэл ба шилжилт хөдөлгөөний урт хугацааны саад тотгороос шалтгаалан саатсан. Араб уран бүтээлчид санхүү, улс төрөөс гадна орон зайн маш олон бэрхшээл болон хязгаарлалтуудтай нүүр тулдаг. Цаашилбал соёлын бүтээгдэхүүнийг түгээх эрх зүйн болон санхүүгийн дутмаг байдал нь түүнийг олон нийт үзэгчдэд хүргэх боломжийг нь хязгаарлаж, ингэснээр түүний үзүүлэх үр нөлөөг багасгадаг. Чухал сэдвүүдийг хөндөж олон улсын наадмуудад хүлээн зөвшөөрөгдсөн баримтат кинонууд олон нийтийн кино театруудаар дамжин үзэгчдэд хүрэхэд саад тулгардаг. Чанартай шүүмжлэлтэй хэвлэмэл бүтээлүүдийн оршин тогтнох эсэх нь эргэлзээтэй болж, тогтмол горимоор үйл ажиллагаа явуулах чадваргүй болдог. Соёлын солилцоог нэмэгдүүлж, Арабын соёлын бүтээгдэхүүнүүдийг түгээх сувгуудыг бүс нутаг болон бүс нутгийг давуулж хөгжүүлэх нь амин чухал. Үүнд орон нутгийн удирдлагын дэмжлэг, мэдлэг ойлголт зайлшгүй шаардлагатай бөгөөд 2005 оны Конвенцийн хэрэгжилт ашиг тусгаа өгөх нь дамжиггүй.”

Уссама Рифахи

Арабын соёл, урлагийн сангийн гүйцэтгэх захирал

Тэнцвэрийг олохуй: Соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний урсгал

Лидиа Дэлумо



2004-2013 онуудын хөгжиж буй болон хөгжилтэй орнууд хоорондын соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний экспортын хувь хэмжээ (БНХАУ, БНЭУ оролгүйгээр)

	Хөгжиж буй орнууд	Хөгжилтэй орнууд (БНХАУ, БНЭУ оролгүйгээр)
2004	85.7%	14.3%
2005	84.9%	15.1%
2006	84.8%	15.2%
2007	83.2%	16.8%
2008	81.5%	18.5%
2009	81.5%	18.5%
2010	78.9%	21.1%
2011	79.4%	20.6%
2012	79.7%	20.3%
2013	80.5%	19.5%

Эх сурвалж: НҮБ-ын Comtrade, DESA/UNSD, 2015 оны 4 дүгээр сар

ГОЛ САНААНУУД

- Дэлхий даяарх соёлын бүтээгдэхүүний экспортын нийт үнийн дүн нь 2013 оны байдлаар 212.8 тэрбум америк доллартай тэнцэж байна. Хөгжиж буй орнууд үүний 46.7%-ийг эзэлж байгаа нь 2004 оныхоос өссөн байна. БНХАУ болон БНЭУ олон улсын зах зээлд хөгжилтэй орнуудтай өрсөлдөж байна.
- Дэлхий даяарх соёлын үйлчилгээний экспортын нийт үнийн дүн нь 2012 оны байдлаар 128.5 тэрбум америк доллартай тэнцэж байсан. Хөгжиж буй орнууд үүний зөвхөн 1.6%-ийг эзэлж байна. Хөгжилтэй орнууд дэлхийн зах зээлийн 98%-ийг эзэмшин давамгайлсаар байгаа бөгөөд энэ нь цахилгаанаар дамжиж буй дуу-дүрсийн болон бусад уран бүтээлийн үйлчилгээний урсгал нэмэгдсэнтэй холбоотой.
- Хөгжиж буй орнуудын хамтын ажиллагааны цар хүрээний тухайд гэвэл хэдийгээр хөгжиж буй орнууд хоорондын худалдааны түвшин өссөн авч соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд онцгой хөнгөлөлт үзүүлэх нөхцөл бүхий хэлэлцээрийн зүйл анги чөлөөт худалдааны гэрээ хэлэлцээрт бага хэвээр байна.
- Бие даасан, институцийн буюу үйлдвэрлэлийн аль ч түвшинд хамаагүй, худалдааны солилцоонд шинэ бодлого нэвтрүүлэх нь соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээнд илүү тэнцвэртэй урсгалыг бий болгоход дэмжлэг үзүүлэх нь тоон баримтуудаас харагдаж байна.



Соёлын агуулга нь үнийн дүн болон утга учиртай холбоотой агаад түүний үнэ цэнийг улс төрийн шийдвэр гаргагчид, соёлын салбарынхан болон иргэний нийгэм тогтоодог. Олон нийтийн хэлэлцүүлэгт тэд хүндтэй орон зай эзлэх ёстой. Би 12 жилийн өмнө Амазигхэ соёл болон дэлхийн хөгжмийн Тимитар наадмыг Мароккын ба олон улсын соёлын олон төрөл зүйлийг сурталчлан тануулах зорилгодоо хөтлөгдөн үүсгэн байгуулсан. Жил бүрийн наадамд хагас сая гаруй хүн оролцдог нь энэ төрлийн уран бүтээлийн илэрхийлэлд олон нийтийн сонирхол байдгийг харуулна. Мароккогийн 'Визад зориулсан хөгжим' нь Африк болон Ойрхи Дорнодын хөгжмийн анхны зах зээл бөгөөд дээр дурдсантай ижил хүсэл эрмэлзлэл буюу олон улсын хамтын ажиллагааг улам ойртуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор үүссэн. Африк ба Ойрхи Дорнодын хөгжмийг олон улсад таниулах, уран бүтээлчдийн шилжилт хөдөлгөөнийг хөнгөвчлөх, Үндэстний соёлын салбарын хөгжлийг дэмжих, хөгжиж буй орнуудын уран бүтээлчдийн нөхцөл байдлыг дээшлүүлэх, хөгжиж буй орнууд хоорондын болон хөгжилтэй орнууд хөгжиж буй орнууд хоорондын соёлын салбарын харилцааг бэхжүүлэх нь нэн тэргүүний зорилтууд юм. Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах ба хөхиүлэн дэмжих Конвенцийн 10 жилийн ойн баяр нь биднийг өөрсдийн хүчин чармайлтаа мөрдөн сахихыг урьж байна. Бид хамтдаа соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний илүү тэнцвэртэй урсгал хийгээд уулзалт, солилцооны шинэ орон зайг бий болгож чадах агаад эдгээр нь ирээдүйд бидний бүтээлч төрөл зүйлийн гол тулгуурууд байх болно."

Брахим Эл Мазнэд

Визад зориулсан хөгжмийн наадмын захирал

Конвенцийг олон улсын чуулга уулзалтуудад таниулан сурталчлах нь

Вероник Гуврмон

The General Conference of the United Nations Educational, Scientific and Cultural Organization, meeting in Paris from 1 to 17 October 2005. Affirming that cultural diversity is a defining characteristic of humanity. Conscious that cultural diversity forms a common heritage of humankind and should be cherished and promoted for the benefit of all. Being aware that cultural diversity enriches and widens world, which increases the range of choice and human capacities and values, and therefore is a marketplace for sustainable development for communities, peoples and nations. Welcoming that cultural diversity, providing access to freedom of democracy, tolerance, social justice and mutual respect between peoples and cultures, is indispensable for peace and security in the most national and international levels. Considering the importance of cultural diversity for the full realization of human rights and fundamental freedoms proclaimed in the Universal Declaration of Human Rights and other universally recognized instruments. Emphasizing the need to incorporate culture as a strategic element in national and international development policies, as well as in international development cooperation, taking into account the United Nations Millennium Declaration focus on its special emphasis on poverty eradication. Taking into account that culture varies across time and space and that this diversity is embodied in the uniqueness and diversity of the identities and social expressions of the peoples and societies making up humanity. Recognizing the importance of traditional knowledge as a source of knowledge and material wealth, and in particular the knowledge systems of indigenous peoples, and its positive contribution to sustainable development, as well as the need for its protection and promotion. Recognizing the need to take measures to protect the diversity of cultural expressions, including their contents, especially in situations where cultural expressions may be threatened by the possibility of extinction or severe impairment. Emphasizing the importance of culture for social cohesion in general, and in particular its potential for the enhancement of the status and role of women in society. Being aware that cultural diversity is strengthened by the free flow of ideas, and that this is favoured by constant exchanges and interaction between cultures. Underlining the freedom of thought, expression and information, as well as diversity of the media, enable cultural expressions to flourish within societies. Recognizing that the diversity of cultural expressions, including traditional cultural expressions, is an important factor that allows individuals and peoples to express and to share with others their ideas and values. Recognizing that linguistic diversity is a fundamental element of cultural diversity, and underlining the fundamental role that education plays in the protection and promotion of cultural expressions. Taking into account the importance of the vitality of cultures, including for peoples belonging to minorities and indigenous peoples, as mentioned in their freedom to create, disseminate and distribute their traditional cultural expressions and to have access to them, as well as to benefit from their own development. Emphasizing the vital role of cultural interaction and creativity, which nurtures and renews cultural expressions and enhance the role of artists and creative professionals in the development of culture for the progress of society at large. Recognizing the importance of intellectual property rights in assisting the vitality of cultural creativity. Being convinced that cultural activities, goods and services have both an economic and a cultural value. Recognizing that human diversity, values and meanings and their diversity need to be treated as a global common good. Noting that while the processes of globalization, which have been facilitated by the rapid development of information and communication technologies, offer opportunities and challenges for enhanced interaction between cultures, they also present a challenge for cultural diversity, namely in view of risks of imbalances between rich and poor countries. Being aware of UNESCO's specific mandate to ensure respect for the diversity of cultures, and to cooperate with international agreements as may be necessary to promote the free flow of ideas in word and image. Welcoming the provisions of the International Instruments adopted by UNESCO relating to cultural diversity and the exercise of cultural rights, and in particular the Universal Declaration on Cultural Diversity of 2001. Adopts this Convention on 20 October 2005.

ГОЛ САНААНУУД

- Европын Холбооны 2005 оноос баталсан худалдааны чиглэлийн 7 хэлэлцээр нь Конвенцтой нэг хийгээд нийжээд байдлаар шууд харилцан хамааралтай. Европын холбоо нь 28 гишүүн орноос бүрдэх агаад 7 худалдааны хэлэлцээр нь өөр 26 улс орныг эгнээндээ нэгтгэдэг. Бүгд нийлээд 55 улс орон болох бөгөөд Европын холбоо ч өөрөө үүнд багтана. Эдгээрээс 50 орон нь Конвенцийн гишүүн юм.
- Конвенцийн зорилт болон үзэл баримтлалуудыг бусад олон улсын чуулга уулзалтуудад сурталчлан таниулах нь худалдааны талбараар хязгаарлагдаагүй. 2005 оноос хойш нийт 250 гаруй олон улсын, бүс нутгийн болон хоёр талын хамтын ажиллагааны байгууллагуудын баримт бичгүүдэд түүнийг ишилж байна.
- 2005 оноос хойш худалдааны гэрээ хэлэлцээрүүдээс зарим нэг соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээг хасах зорилгоор "соёлын хөнгөлөлт"-ийн арга хэмжээг ашиглах явдалд ахиц гарсаар байна.
- Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд шинэ худалдааны гэрээ хэлэлцээрүүд бий болсон бөгөөд тухайлбал соёлын хамтын ажиллагааны Тогтоол нь худалдааны гэрээ хэлэлцээрүүдэд нэгдэн орсон. Соёлын хамтын ажиллагааны Тогтоол нь соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний тодорхой шинжүүдийг хүлээн зөвшөөрснөөс гадна ялангуяа хөгжиж буй орнуудын уран бүтээлчид, соёлын мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөнийг дэмжих үүднээс хөнгөлөлттэй горимд хамаатуулахыг дэмжсэн. Европын холбоо болон Төв америкийн чөлөөт худалдааны хэлэлцээрт Соёлын хамтын ажиллагааны Тогтоол нэгдсэн нь энэ талын хамгийн сайн практикт тооцогдож болно.

Конвенцийг хоёр талын болон бүс нутгийн худалдааны гэрээ хэлэлцээрүүдэд хэрэгжүүлэх аргууд

Зарим нөхцөл
болзлыг
томъёолох

Тодорхой үүрэг
амлалтын эерэг
жагсаалтыг хэрэглэх

Соёлын
хөнгөлөлтийг
эдлүүлэх

Соёлын
протокол баримт
бичгийг батлах

Конвенцийн
харилцан
хамааралд нэгдэх



Соёлын илэрхийллийн төрөл зүйлийг хадгалан хамгаалах ба хөхүүлэн дэмжих чухал Конвенцийн 10 жилийн ойг тэмдэглэх ЮНЕСКО-гийн санаачилгыг ёсчлон мэндчилж байна. Европын холбооны худалдаа эрхэлсэн төлөөлөгчийн хувиар миний бие энэхүү эх бичгийг бэлтгэхийг дэмжин ажилласан бөгөөд Европын холбоо нь Конвенцийн төслийн үе шатад маш чухал үүрэгтэй оролцсонд би хувьдаа их бахархдаг. Энэ бол урт хугацааны түүхэн дэрх шийдэмгий алхам байсан. 1990-ээд онд Жак Делорын удирдлаган дор ажиллаж байсан Европын Комисс нь „Соёл нь аливаа бусад зүйлтэй адил бараа бүтээгдэхүүн биш” гэснийг эргэн санаж олон улсын худалдааг чөлөөлсөн Уругвайн хэлэлцээрт соёлын үйлдвэрлэлийг оруулахыг эсэргүүцсэн юм.

Гэвч энэхүү 'хамгаалалтын' хандлагаас гадна худалдааны дүрмийг гүйцэтгэхэд зүг чиг болохуйц олон улсын хэрэгсэл шаардлагатай байсан бөгөөд улс орон бүрийн өөрсдийн бүтээлч байдал болон соёлын илэрхийллийг дэмжихэд тэрхүү гэрээ хэлэлцээрүүд таарч тохирч байгаа эсэхийг дор бүрнээ шийдэхийг зөвшөөрсөн. ЮНЕСКО энэхүү сорилттой тулгарч түүнийг даван туулсан. Илүү иргэнхсэн даяаршлын төлөө ажиллаж буй хэнбуй ч үр дүнд нь сэтгэл хангалуун байсан болов уу. Конвенц нь соёлыг Үндэстний болоод орон нутгийн хил хязгаараар зааглахгүйгээр харин ч эсрэгээрээ соёлыг илүү тэнцвэртэй байдлаар (конвенц нь уран бүтээлчдийн чөлөөт шилжилт хөдөлгөөн хийгээд соёлын солилцоог хөхүүлэн дэмжихээс гадна соёлын үйлдвэрлэлийн төвлөрлийг зохицуулахыг хичээж, олон ургалч үзэл, бүтээлч байдлын олон төрөл зүйлийг хүндэтгэн үзэж байгаа эсэхийг нягтладаг) хуваалцахад тусалдаг. Ийм учраас Конвенцийн хэрэгжилтийн хяналт нь чухал юм."

Паскал Лами

Дэлхийн худалдааны байгууллагын ерөнхий захирал асан


Соёлын тогтвортой хөгжил

Дэвид Тросби



2007-2014 онуудад Соёлын төрөл зүйлийн Санд хуримтлагдсан хувь нэмрийн нийлбэр (Америк долларын одоогийн ханшаар)

Эх сурвалж: <http://en.unesco.org/creativity/ifcd/fundraising/donations/parties>



ГОЛ САНААНУУД

- >>> Конвенцийн хэрэгжилтийн тогтвортой байдлын заалтыг соёлын тогтвортой хөгжлийг бий болгох стратегийн томъёолол гэж тайлбарлаж болох агаад энэхүү ойлголт нь хөгжлийн үйл явцад өсөлт, эрх тэгш байдал хийгээд соёлын нэгдмэл байдлыг чухалчилсан хамрах хүрээг багтаасан, соёлын болон эдийн засгийн хөгжлийн цар хүрээг хоёуланг нь авч үзнэ.
- >>> Соёлын үйлдвэрлэл нь эдийн засаг, соёлын аль алиных нь хувьд тогтвортой байх хөгжилд чиглэсэн бодлогын үндсэн зорилт нь байж болох бөгөөд энэхүү соёлын үйлдвэрлэлийн өсөлтийг дэмжсэн бодлогын санаачлага нь нийгэм-эдийн засаг, соёл, хүрээлэн буй орчинд урт хугацааны даацтай, үр ашиг өгч чадах юм.
- >>> Донор орнуудад өөрсдийн Албан ёсны Хөгжлийн Тусалцааны (ODA) стратеги болон хөтөлбөрүүдээрээ дамжуулан хөгжиж буй орнуудад соёлыг тогтвортой хөгжилд нэгтгэхийг хөхиүлэн дэмжих чамгүй бололцоо бий бөгөөд энэхүү дэмжлэгийн тодорхой арга замуудын нэг нь дэмжлэг тусалцаа хүртэж буй орнуудын шинэ мэдээлэл, харилцаа холбооны технологудыг ашиглах боломжид тулгарч буй саад бэрхшээлийг даван туулахад нь техникийн тусламж болон мэргэжлийн зааварчилгаа өгөх, хөгжиж буй орнуудын олон улсын зах зээлд өөрсдийн соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг гаргах холбоог дэмжих зэрэг болно.



Европын холбоо нь Европын холбоо дотроо болон гадагшаа соёлын салбарт маш их сонирхолтойгоос гадна үүрэгтэй. Европын холбоо нь 2005 оны Конвенцид гарын үсэг зурсныхаа хувьд энэхүү хэлэлцээрийн үзэл баримтлалд бүрэн үүрэг хүлээдэг.

Соёлыг ерөнхийд нь нийтийн ашиг тус гэж үзэж болно. Соёлоор дамжуулж бид илэрхийллийн эрх чөлөө, ардчилал, хүлээцтэй байдал, нийгмийн шударга ёс болон харилцан хүндлэл зэрэг зарчим, үнэ цэнийг дэлгэрүүлж, бэхжүүлэх боломжтой.

Соёлын амьдрал дахь иргэдийн оролцоо нь нийгмийн нягтруулж, нийгмийн бүлгийг хүчирхэг болгодог. Бүтээлч салбар нь дэлхий дахинд болон Үндэстний, цаашилаад бүс нутгийн түвшинд олныг хамарсан, тогтвортой өсөлтийн нэг хүчин зүйл юм. Мөн түүнчлэн соёлын арга хэмжээ нь нийгмийн, гадуурхагдсан бүлгүүдийн амьжиргааг хангах боломжтой.

Соёлын олон улсын хамтын ажиллагаа болон хөгжил дэх чухал үүргүүд Европын холбооны үйл хэргүүдэд тусгалаа олсон бөгөөд тухайлбал Европын холбоо нь Дундад Тэнгис ба Африк, Карибийн ба Номхон далайн бүс нутгуудад соёлын ба бүтээлч үйлдвэрлэлийг хөхиүлэн дэмжихэд санхүүгийн тусалцаа үзүүлдэг. Бид соёлын хөтөлбөр болон төслүүдийн өөрчлөгч үүрэг оролцоо нь илэрхийллийн эрх чөлөө, эрх тэгш байдал (хүйсийн тэгш байдал мөн орно) болон үзэл санааны чөлөөтэй урсгал зэрэг үзэл санаанд шингэсэн гэдгийг ухамсарладаг.

Европын холбоо нь Конвенцийн хэрэгжилтийг хөгжиж буй түнш 13 орны соёлын засаглалыг дээшлүүлэх үзэл баримтлалын хамтаар хөхиүлэн дэмжсээр ирсэн. Конвенц нь тэрхүү орнуудад соёлын бодлогоо хөгжүүлэхэд нь болон Конвенцийн өөрийнх нь соёлын бодлогын ач холбогдлыг тануулан сурталчлах арга хэрэгсэл болсонд нь миний бие сэтгэл хангалуун байна.”


Нэвэн Мимика

Олон улсын хамтын ажиллагаа ба хөгжлийн Европын төлөөлөгч



Эмэгтэйчүүдийг бодлогын шалгуурынхаа төрөлд бодлогынхоо зорилт болгон оруулсан гишүүн орнуудын хувь хэмжээ

Эх сурвалж: QPRs, 2012-2014



Эмэгтэйчүүд бүтээгчид болох нь: Хүйсийн тэгш байдал Амму Жозеф

ГОЛ САНААНУУД

- Эмэгтэйчүүд дэлхийн ихэнх орнуудын бүтээлч салбарт хүчтэй орон зайг эзэлж байна. Гэсэн хэдий ч соёлын байгууллагууд болон үйлдвэрлэлд бодлого гаргах түвшний ажлын байранд бага хувийг төлөөлсөн хэвээр байгаа юм.
- Соёлын ажил хэргийн дэвшил болон оролцоонд эмэгтэйчүүдэд тулгарч буй олон тооны бэрхшээл нь шударга бус байдлыг бий болгоод зогсохгүй тэдний соёлын эрхийг зөрчдөг. Энэ нь цаашлаад соёлын олон төрөл зүйлийн ач холбогдлыг бууруулахаас гадна уран бүтээлч нийгмийн бүлэг болон салбарт саадгүй нэвтрэх чадамж бүхий бүтээлч эмэгтэйчүүдэд саад тотгор учруулж байна.
- Олон улс орон эмэгтэйчүүдэд боломж олгох болон тэдний бүтээлч эдийн засагт оруулж буй хувь нэмрийг өсгөн нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой алхмуудыг хийсээр байна. Гэвч соёлын салбар дахь хүйсийн тэгш байдлыг хангах хэрэгцээ шаардлагад анхаарал хандуулах явдал хараахан хангалттай бус байна.
- Соёлын салбар дахь хүйсийн тэнцвэртэй бус байдалтай тэмцэхэд нөлөөлж буй хамгийн ноцтой саад тотгор бол хүйсээр нь салган хуваасан тоо баримт юм. Гагцхүү мэдээлэлд суурилсан хандлага хүйсэд тулгуурласан одоогийн өрөөсгөл хандлага хийгээд саад тотгорыг үгүй болгож чадна.
- Хүйсийн тэгш байдал, соёлын эрх болон соёлын төрөл зүйл хоорондын хоёрдмол харилцааг хүлээн зөвшөөрсөн нэгдмэл хандлага ихээхэн ач холбогдолтой. Соёлын олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах эрхэм зорилго нь энэхүү зорилгыг хэрэгжүүлэх бүхий л оролдлогод хүйсийн тэгш байдлыг хүлээн зөвшөөрөхөд гол анхаарлаа нэгтгэсэн цагт л биелэх боломжтой.
- Конвенцийн баримт бичиг, түүний амин сүнс нь хүйсийн тэгш байдлын үзэл баримтлалыг хүний эрхийн, тэр тусмаа соёлын эрхийн тулгын чулуу хэмээн хөхиүлэн дэмждэг. Конвенц нь соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээний салбар дахь эмэгтэйчүүд, уран бүтээлчдийг хүлээн зөвшөөрч, хөхиүлэн урамшуулсан, хүйсийн тэгш байдлыг хангахад чиглэсэн бодлого болоод шалгуурыг дэмжихийг маш ойлгомжтой тусгасан.



Африк тивийн эмэгтэй, бүтээлч хийгээд ЮНИСЕФ-ийн элч болохынхоо хувьд миний бие өдөр бүр хүйсийн тэгш бус оролцоотой тулгардаг. Бид хүн амын тал хувийг эзэлдэг ч бидний дуу хоолой ямагт бүдгэрч, бидний хувь нэмрийг үл тоомсорлодог. Энэ нөхцөл байдлыг сайжруулах олон зүйл хийж болох агаад соёл нь үүнийг эергээр өөрчлөхөд туслах олон арга замын нэг юм. ЮНЕСКО-гийн Соёлын илэрхийллийн төрөл зүйлийг хадгалан хамгаалах ба хөхиүлэн дэмжих Конвенц нь эмэгтэйчүүдийг соёлын илэрхийллийн үйлдвэрлэгч хийгээд бүтээгч болохынх нь хувьд хүлээн зөвшөөрч дэмжих замаар энэхүү зорилгыг хэрэгжүүлэхэд тус болж чадна. Энэ нь Засгийн газруудад эмэгтэйчүүдэд хүртээмж, оролцоо болон уран бүтээлийн эрх чөлөөний дэмжлэг үзүүлэхэд туслах хүчтэй хэрэгсэл байж болно. Эмэгтэйчүүдийг юу хэлэхийг сонс, тэдэнд чөлөөлөх хэрэгсэл өг, шинэ хил хязгаарыг даван туулахад нь тусал, өөртөө итгэх итгэлийг өг, бүтээн туурвихыг нь урамшуул, тэдэнтэй хүндэтгэлтэйгээр харьц. Энэ нь эмэгтэйчүүдийн өдөр тутмын сэтгэл санааг өөрчлөх энгийн хандлагууд юм. Тэдэнд ингэж боломж олгосноор тэдний ертөнцийг үзэх үзлийг маш их зүгшрүүлэхээс гадна залуу эмэгтэйчүүдэд хаана ч өөрсдийн дуу хоолойг олоход нь, өөрсдийн өв уламжлалаар бахархахад нь, өөрсдийн соёлыг шинэчилж түүнийгээ дэлхий ертөнцтэй хуваалцахад нь урам зориг өгч, миний хийснийг хийх урмыг бадраана гэдэгт би итгэж найддаг. Энэ нь бүхэлдээ хүн төрөлхтөнд ашиг тусаа өгөхөөс гадна дэлхий ертөнцийг илүү сайн сайхан болгох болно.”

Анжелик Кидио

Дуучин, Олон улсын зохиолчид ба хөгжмийн зохиолчдын холбооны дэд ерөнхийлөгч

Уран бүтээлийн эрх чөлөөнд тулгарч буй сорилтууд

Олэ Рейтов



ГОЛ САНААНУУД

- >>> Уран бүтээлийн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх ба хадгалан хамгаалах нь зөвхөн уран бүтээлчид хийгээд тэдний бүтээлч үйл ажиллагаатай хамааралтай биш агаад соёлын мэргэжилтнүүдийн бүхий л эрхтэй мөн хамаатай.
- >>> Эрх чөлөөний суурь зарчмууд нь иргэд, нийгмийн сайн сайхан амьдрал, нийгмийн хөгжлийн динамик болон урлаг, соёлын ба бүтээлч үйлдвэрлэлийн салбарын тогтвортой байдлын нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь юм.
- >>> Уран бүтээлийн эрх чөлөө болон эдийн засгийг хязгаарлах нь уран бүтээлчдийг өөрсдийн илэрхийлэл болон амьжиргаанаас нь салгаад зогсохгүй урлаг болон тэдний үзэгчидтэй холбогдогсод аюултай хүрээлэн буй орчныг үүсгэнэ.
- >>> 2014 онд Фриймюз (Хөгжмийн илэрхийллийн эрх чөлөө) уран бүтээлийн илэрхийлэлтэй холбогдолтой 237 халдлагыг бүртгэсэн. Уран бүтээлийн эрх чөлөөний заналхийлэл нь сэтгүүлчид болон хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд рүү чиглэсэн заналхийлэлтэй харьцуулахад дутуу мэдээ юм. Энэ нь бүтээлч-чөлөөт илэрхийлэлд тулгарч буй жинхэнэ далайцтай сорилтын үнэн дүр зургийг хязгаарлахад хүргэдэг. Нэн ялангуяа нийгмийн асуудал хөнддөг уран бүтээлчид болоод хүмүүст хандсан биет заналхийллийг үүнд хамааруулж ойлгож болно.

Уран бүтээлийн эрх чөлөөний эрхийг зөрчсөн тохиолдлууд (2010-2013)

Эх сурвалж: 19 дүгээр заалт, 2010-2013

Уран бүтээлийн илэрхийллийг хязгаарласан суурь



35.7%

Улс төрийн шүүмж



22.4%

Хүйс, хүйсийн ялгаа болон нүцгэн байдал



16.6%

“Уламжлал” эсвэл шашны үнэт чанар



10.8%

Гомдоох ба доромжлох

4.9% Төрийн бэлгэдлийг доромжлох

4.7% Үндэстний аюулгүй байдал

1.8% Нийтийн хэв журам

0.7% Хувийн нууцлал



Уран бүтээлийн илэрхийлэл нь тансаглал бус шаардлага бөгөөд хүн бүрийг, хувиараа болон хамтдаа, өөрсдийн хүнлэг чанар хийгээд ертөнцийг үзэх үзлийг хөгжүүлэх, илэрхийлэх боломжийг олгодог, хүнлэг чанарыг тодорхойлогч нэг элемент, хүний эрхийн суурь зарчим юм. Иргэний болон улс төрийн нийгэм-эдийн засаг, соёлын эрх ба Хүний эрхийн нийтлэг тунхаглал зэрэг олон улсын хоёр гол хэлэлцээрт тодорхой туссан уран бүтээлийн эрх чөлөөний сэдэвт 2013 онд олон улсын хүний эрхийн чуулга уулзалт анхаарал бага хандуулдаг байв. Би энэ үед анх тус сэдвийг судалж эхэлсэн юм. Уран бүтээлчид болон уран бүтээлийн илэрхийллийн заналхийлэл тодорхой баримттай байсан авч цөөн тооны уран бүтээлч Нэгдсэн Үндэстний Байгууллагын хүний эрхийн системтэй холбогдсон юм.

Энэхүү асуудалд түүнээс хойш тасралтгүй анхаарлаа хандуулж байгаагийн хувьд, миний бие, уран бүтээлчид ба уран бүтээлийн бүтээлч байдал нийгэмд чухал үүрэг гүйцэтгэж байгааг илүү их ухамсарладаг болсон, бас уран бүтээлчийн дуу хоолой өөр бусад арга хэрэгслээр намжаагүйг бататган тэмдэглэхэд таатай байна. Соёлын илэрхийлэл нь зөвхөн зугаацуулдаггүй бөгөөд нийгмийн хэлэлцүүлэгт хувь нэмрээ оруулж биднийг сэтгэн бодоход уриалдаг. Уран бүтээлийн эрх чөлөөний эргэн тойрон дахь талуудын оролцоо өсөн нэмэгдэж буй нь сайшаалтай. Гэвч уран бүтээлийн ажилд, тэр тусмаа нийтийн эзэмшлийн орон зайд нэвтрэх эрх болон оролцоог хангах талаар маш олон зүйл хийх шаардлагатай. “Ижилсэл, үнэт чанар ба утга учир”-ын тухай одоогийн шүүмжлэлт сэтгэлгээг идэвхжүүлснээр бид өөрсдийн амьдралыг сонгохыг хүсдэг. Уран бүтээлийн илэрхийлэл ба бүтээлч байдал нь нийгмийг нэгдүүлэх үйл явцаас өдөр тутмын амьдрал хүртэлх олон талбарт маш чухал үүргийг гүйцэтгэдэг. Уран бүтээлчдийн нийгмийн үнэлэмжтэй холбоотой энэхүү хандлага нь ирээдүйн үйл хэргийг хөтлөхөд туслах үнэлж баршгүй арга хэрэгсэл юм.”


Фарида Шахээд

Соёлын эрхийн асуудал харуцсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусгай илтгэгч асан

Гол дүгнэлтүүд

ЗОРИЛГО 1

СОЁЛЫН ЗАСАГЛАЛЫН ТОГТВОРТОЙ СИСТЕМИЙГ ДЭМЖИХ



■ Соёлын олон төрөл бүтээгдэхүүн болон үйлчилгээнүүдийн бүтээмж, үйлдвэрлэл, тархалт, түгээлт ба таашаалын нэмүү өртгийн гинжин хэлхээг дэмжих зорилгоор сүүлийн 10 гаруй жил соёлын шинэ бодлого, шалгуур болон механизмуд хэрэгжсээр байна. Технологи нь шинэ дуу хоолой ба авьяастанд арга замыг нээн өгөхийн хажуугаар иргэний оролцооны шинэ хэлбэрүүд нь нэмүү өртгийн гинжин хэлхээн дэх соёлын бүтээгдэхүүн болон үйлчилгээ хоорондын заагийг дахин тодорхойлж, шинэ бодлого болон шалгуурыг загварчлан боловсруулахтай холбоотой шинэ асуултуудыг тавьдаг.

■ Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг шийдвэрлэгч ба хөдөлгөгч хоёр чухал бодлогын салбар байна. Энэ нь олон нийтийн хэвлэл мэдээлэл ба цахим технологи юм. Бодлого, цаашлаад магадгүй Конвенцийн эрх зүйн хамрах хүрээ нь мэдээллийн хуулийн эрх чөлөө, харилцаа холбооны бодлого, и-худалдаа болон интернэт засаглалтай холбоотой асуултуудыг багтааж, цар хүрээгээ тэлэх шаардлагатай нь улам тодорхой болж байна.

■ Засаглалын системийн хувьд, олон тооны иргэний нийгмийн оролцогч талууд бодлого боловсруулалт болон хэрэгжилтэд оролцох нь чухал. Иргэний нийгмийн 'соёлын хоточ нохой'-ны үүрэг шаардлагатай хэмжээнд хөгжиж чадаагүй ба иргэний нийгмийн дуу хоолойны олон төрөл зүйл хангалтгүй хэвээр байна. Аль алиныг нь сайжруулах шаардлагатай. Дэлхийн бүс нутгуудад дутагдалтай байгаа ил тод мэдээллийн бодлогын хяналт болон үр дүнгийн үнэлгээнд шаардлагатай үндэслэлтэй тоон баримтыг бий болгохын тулд иргэний нийгэм ба олон нийтийн салбарын мэргэжилтнүүд хоорондын хамтын ажиллагаа чухал.

■ Дэлхийн улс орнууд өөрсдийн бүтээлч салбарын өсөлт, хөгжлийг дэмжих арга хэмжээг авч байна. Шинэ бодлогыг үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт болон шинэ бүтэц боловсруулан дэмждэг. Гэвч олон улсын түвшинд соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний тэнцвэртэй урсгалд хүрэхээс өмнө туулах урт зам байна. ЮНЕСКО-гийн Статистикийн хүрээлэнгийн боловсруулсан шинэ мэдээллээс харвал дэлхий даяарх соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний экспорт 2013 оны байдлаар 212.8 тэрбум америк долларт хүрсэн бөгөөд үүний 46.7%-ийг хөгжиж буй орнууд эзэлж байна. Гэвч хэрэв энэхүү үзүүлэлтээс БНХАУ болон БНЭУ-ыг хасвал хөгжиж буй орнуудын дийлэнх олонхи нь соёлын бараа бүтээгдэхүүний экспортод өчүүхэн үүрэг гүйцэтгэж буйг харж болно. Мөнхүү мэдээллээс харвал дээр дурдсан хугацаанд соёлын үйлчилгээ ойролцоогоор 128.5 тэрбум америк долларт хүрчээ. Үүнд кино, хөгжим эсвэл интэрнэтээс татаж авсан ном, бүжиг юм уу хөгжмийн тоглолтууд багтана. Хөгжиж буй орнуудын эзэлж буй хувь нь тун харамсмаар буюу ердөө үлдсэн 1.6% юм. Тийм учраас Конвенц зорилгодоо хүрэхээс урьтаад улс оронд давуу эрх олгосон горимын шалгуурыг яаралтай нэвтрүүлэх шаардлагатай.

■ Нэлээд улс орон бүтээлч мэргэжилтнүүдийн хязгаарлалтыг хөнгөлсөн шалгууруудыг нутагшуулсан боловч дэлхийн зарим хэсэгт уран бүтээлчид чөлөөтэй аялж чадахгүй хэвээр байна. Энэхүү харамсмаар нөхцөл байдал соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний тэнцвэртэй урсгалд саад болж байна. Ялангуяа хөгжиж буй орнуудын уран бүтээлчид ба бусад соёлын мэргэжилтнүүдийн шилжилт хөдөлгөөнийг дэмжсэн бодлого нь уран бүтээлчид ба соёлын мэргэжилтнүүдийн шинэ зах зээлд нэвтрэх боломжийг өргөжүүлж, хамтын ажиллагааны бололцоог олох талаасаа чухал юм.

■ Конвенц нь шинэ худалдааны бүтцийн хэрэгжилт болон гэрээ хэлэлцээрүүдийн хамтаар сүүлийн 10 жилд эерэг үр нөлөө авчирсан бөгөөд тодруулбал Соёлын Хамтын ажиллагааны Тогтоол худалдааны гэрээ хэлэлцээрүүдэд нэгдсэнээр соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний онцлог байдал хүлээн зөвшөөрөгдөж, хөгжиж буй орнуудын соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бүс нутаг, олон улсын зах зээлд нийлүүлэх боломжийг дээшлүүлсэн. Гэвч үүний үр дүнд дэлхий нийтээр соёлын бүтээгдэхүүн ба үйлчилгээний тэнцвэртэй урсгал хангагдах эсэх нь ойлгомжгүй хэвээр үлдсэн.

ЗОРИЛГО 2

СОЁЛЫН БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН БА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЭНЦВЭРТЭЙ УРСГАЛЫГ БИЙ БОЛГОХ ХИЙГЭЭД УРАН БҮТЭЭЛЧ БОЛОН СОЁЛЫН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ



ЗОРИЛГО 3

СОЁЛЫГ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ХАМРАХ ХҮРЭЭНД НЭГТГЭХ



ЗОРИЛГО 4

ХҮНИЙ ЭРХ БОЛООД СУУРЬ ЭРХ ЧӨЛӨӨГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ



- 2005 оны Конвенц ба саяхан батлагдсан 2030 он хүртэлх Тогтвортой хөгжлийн хөтөлбөр хоёул бүгдийг хамарсан тогтвортой эдийн засгийн өсөлт, хамтын хөгжил цэцэглэлт болон нийцтэй ажлын байрны нөхцөлийг бий болгоход хувь нэмрээ оруулна.


- Соёлын болон бүтээлч үйлдвэрлэл нь эдийн засаг ба соёлын хувьд тогтвортой байхад чиглэсэн хөгжлийн бодлогын гол зууч байх боломжтой. Дээрх үйлдвэрлэлүүдийн өсөлтийг дэмжсэн бодлогын санаачлагууд нь урт хугацааны нийгэм, соёл, хүрээлэн буй орчны ашиг тусыг авчрахаас гадна соёлын эх үүсвэрүүдийн түгээлтэд тэгш байдлыг бий болгож, соёлын оролцоонд шударга, эрх тэгш, үл ялгаварлан нэвтрэх боломжийг олгоно.

- Гэвч олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны хамрах хүрээ болон хөтөлбөрүүдээр дамжуулан соёлыг хөхиүлэн дэмжих нь 2005 оноос хойш буурсан бөгөөд ийм учраас энэ нь дэлхий нийтийг хамарсан сорилт болоод байна.

- Уран бүтээлчид ба соёлын мэргэжилтнүүдийн илэрхийлэл, мэдээлэл болон харилцаа холбооны суурь эрх чөлөөг дэмжих хийгээд хадгалах хамгаалах нь соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг бүтээх, түгээх ба хүртэх боломжийн урьдчилсан нөхцөл нь юм. 2014 оны байдлаар Фриймюз дэлхий даяар уран бүтээлийн илэрхийллийг заналхийлсэн 237 тохиолдлыг бүртгэсэн.

- Уран бүтээлийн эрх чөлөө болон уран бүтээлийн илэрхийллийг хүртэх боломжийг хязгаарлах нь соёл, нийгэм-эдийн засагт гарз хохирлыг учруулаад зогсохгүй, уран бүтээлчдийг өөрсдийн илэрхийлэл болон амьжиргаанаас нь салгаж, улмаар урлаг болон үзэгчдэд аюултай орчныг үүсгэнэ.

- Эмэгтэйчүүд дэлхийн ихэнх орны бүтээлч салбарт хүчтэй орон зайг эзэлж байна. Гэсэн хэдий ч соёлын байгууллагууд болон үйлдвэрлэлийн соёлын мэргэжил хийгээд бодлого гаргах түвшний ажлын байранд бага хувийг төлөөлсөн хэвээр байгаа юм. Эмэгтэйчүүдийг соёлын илэрхийллийн бүтээгч, үйлдвэрлэгч мөн, түүнчлэн соёлын амьдралд оролцогч иргэд болохынх нь хувьд хүлээн зөвшөөрсөн, хөхиүлэн дэмжсэн, сурталчлан таниулсан шинэ бодлого болон шалгуурууд шаардагдаж байна.



СОЁЛЫН БОДЛОГЫГ ДАХИН ТОДОРХОЙЛОХ НЬ

Ойн баярууд бол эргэцүүлэл хийгээд төлөвлөлтийн цаг юм.

ЮНЕСКО-гийн Соёлын илэрхийллийн олон төрөл зүйлийг хадгалан хамгаалах ба хөхиүлэн дэмжих 2005 оны Конвенцийн 10 жилийн ойн баяр нь гишүүн орнуудад болон төрийн бус оролцогч талуудад Конвенцийн үүслийг эргэн санах, ололтоо шүүмжлэлтэйгээр эргэцүүлэх, улмаар үүнд тулгуурлан дараагийн 10, 20, 30 жилийн Конвенцийн хэрэгжилтийн хангах хүсэл эрмэлзэл бий болгох чухал бололцоог олгодог.

Ойн баярын хүрээнд тавьсан асуултуудын нэг нь Конвенцийн хэрэгжилт нь түүнд алсын харааг тусгасан эсэх тухай байсан. Өөрөөр хэлбэл Конвенцийн хэрэгжилт нь төслийг төлөвлөн зохиогчдын урьдчилан тооцоолсон шиг эерэг үр дүн авчирсан уу? Соёлын засаглалын тогтвортой системийг дэмжих, соёлын бараа бүтээгдэхүүн ба үйлчилгээний тэнцвэртэй урсгалыг бий болгох хийгээд уран бүтээлч болон соёлын мэргэжилтнүүдийн хөдөлгөөнийг нэмэгдүүлэх, соёлыг тогтвортой хөгжлийн хамрах хүрээнд нэгтгэх, хүний эрх болоод суурь эрх чөлөөнүүдийг хөхиүлэн дэмжих гэсэн Конвенцийн гол 4 зорилгод хүрэхийн тулд ямар алхмууд хийсэн бэ?

Энэхүү олон улсын тайлангийн шинэ цувралууд нь Конвенцийн зорилгын хэрэгжилтийг цаг хугацааны явцад хэрхэн өөрчлөгдөн хөгжсөнийг хянах цогц үзүүлэлтийг баримттайгаар танилцуулдаг. Одоог хүртэл гишүүн орнуудын ирүүлсэн хугацаат тайлан хийгээд бусад эх сурвалжуудад тулгуурласан энэхүү шинэ хэвлэлт нь цахим, олон нийтийн хэвлэл мэдээлэл, давуу эрхийн горим, хүйсийн тэгш бус байдал болон уран бүтээлийн эрх чөлөө гэх мэт ялангуяа хөгжиж буй бодлогын салбаруудад тулгараад буй сорилтуудын талаарх мэдээллийг цуглуулах, түүнийг хуваалцах анхны хүчин чармайлт юм. Энэхүү тайлан нь соёлын бодлого Конвенцийг хэрэгжүүлэх хүчин чармайлтуудын үр дүнд хэрхэн дахин тодорхойлсоныг хянан шинжилдэг.

Үүнээс гадна мөнхүү тайлан нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын 2030 оны Тогтвортой Хөгжлийн Хөтөлбөрийг баримтаар хангах зорилготой юм.

<http://en.unesco.org/creativity/>

2005 оны Конвенцийн
дэлхийн тайлан

2015